

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ХЭЛТЭС, АГЕНТЛАГ, СУМДЫН
2018 ОНЫ 08 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

2018.09.04

Сүхбаатар сум

Нэг.Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

1. Аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:

Аймгийн хэмжээнд энэ оны ургац тогтоолтын дүнгээр нийт 194,7 мянган га-д тариалснаас 3280 га тэжээлд шилжиж, 5012 га-гийн ургац алдаж, 186,4 мянган га талбайгаас 12,0 цн буюу 223,8 мянган тн ургац хураан авах төлөвтэй байна. Үүнээс 135,5 мянган га улаанбуудай хураахаас 12,9 цн буюу 175,0 мянган тн, 9,4 мян га бусад үр тариа хураахаас 12,2 цн буюу 11,4 мян тн, 18,9 мян га малын тэжээл хураахаас 12,0 цн буюу 23,1 мянган тн, 25,8 мянгага тосны ургамал хураахаас 5,5 цн буюу 14,1 мянган тн, 2651 га-д төмс хураахаас 118,4 цн буюу 31,3 мянган тн, 2613 га-д хүнсний ногоо хураахаас 118,7 цн буюу 31,0 мянган тн ургац хураан авах төлөвтэй байна.

Одоогийн байдлаар 135.5 мянган га-аас 1094 га-д ангилан хийж, 120 га-г шууд хурааж, 20 цн буюу 360 тн урга, 458.5 га-д төмс хураалт хийж, нэгж талбайгаас 129 цн буюу 5910.4 тн, 540.6 га-гийн хүнсний ногоог хурааж, нэгж талбайгаас 137.0 буюу 7433.0 тн ургац хураан аваад байна.

Энэ намрын ургац хураалтанд нийт ажиллах 465 үр тарианы комбайн, 179 ангилангийн жатка, 29 төмсний комбайн, 32 төмс ухагч, 25 төмсний сортлогч, 221 будаа цэвэрлэгч, 75 үр сортлогч, 298 будаа ачигч, 14 механикжсан үтрэмийн техникүүдийн засвар, үйлчилгээ 93,2 хувьтай хийгдэж байна. Мөн ОХУ-аас орж ирсэн техникээс аж ахуйн нэгж, иргэд авч техник шинэчлэл хийгдэж байна. Төмс 2654 га талбайгаас га-гийн ургац 118,2 цн буюу 31379 тн, хүнсний ногоо 2616 га талбайгаас га-гийн ургац 118,6 цн буюу 31012 тн ургац хураан авна.

Аймгийн хэмжээнд 2018-2019 оны өвөлжилт, хаваржилтыг эрсдэл багатай даван туулах зорилгоор ажлын төлөвлөгөөг гарган хэрэгжүүлэн ажиллаж байна. 2018-2019 оны өвөл, хавар аймгийн 17 сумын 56 багт, 9499 малчин болон мал бүхий өрхөд 1.6 сая толгой мал өвөлжихөөр зохион байгуулалтын арга хэмжээ авч байна. Өнөөдрийн байдлаар аймгийн өвс тэжээлийн аюулгүйн нөөцдөө 60 тн өвс, 20 тн ногоон тэжээлийг бэлтгэхээр иргэн, аж ахуйн нэгжтэй гэрээ хийгдсэн. Малчдын түвшинд 121.0 мянган тонн байгалийн хадлан, 24.2 мянган тн хүчит тэжээл, 4.8 мянган тн эрдэс тэжээл бэлтгэхээр төлөвлөн ажиллаж байна.

2018 оны 08 дугаар сарын 16-ны өдөр тус суманд Монгол Улсын Шадар сайд, Улсын Онцгой комиссын дарга Ө.Энхтүвшин, Сэлэнгэ аймгийн Засаг дарга Ш.Оргил болон Улсын Онцгой комиссын ажлын хэсэг ажиллалаа. Үер усны нөхцөл байдал, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, өвөлжилтийн бэлтгэл, бэлэн байдлыг хэрхэн хангаж байгаа талаарх мэдээллийг сонсож, Сэлэнгэ, Дархан уул аймгийн удирдлагуудад, орон нутгийн эрчим хүчний үйлдвэр, нийт аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн өвөлжилтийн бэлтгэлийг сайтар хангуулж, нүүрс, түлшийг бэлтгүүлж, шаардлагатай аюулгүйн нөөцийг бүрдүүлэх, орон сууцны цэвэр бохир ус, дулааны шугам хоолой, авто замын засвар үйлчилгээг хугацаанд нь хийж дуусгах, ургац хураалтад ажиллах хүн хүч, техникийн бэлтгэл, бэлэн байдлыг хангуулан цаг агаарын гамшигт үзэгдлээс ургацаа хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах, үерийн улмаас учирсан хохирлын хэмжээ, гамшгийн хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгоход зарцуулсан зардлыг нарийвчлан тогтоох үүрэг чиглэл өглөө.

Аймгийн Засаг даргын тамгын газар, Монголын Хөдөө аж ахуйн хоршоологчдын Үндэсний холбоо, аймгийн Хөдөө аж ахуйн хоршоологчдын холбоотой хамтран “Хөдөө аж ахуйн тогтвортой хөгжилд хоршоодын оролцоо” сэдэвт Улсын зөвлөгөөнийг

8 дугаар сарын 12-15-ны өдрүүдэд амжилттай зохион байгууллаа. Зөвлөгөөнд нийт 16 аймгийн 230 гаруй төлөөлөгчид оролцон “Хөдөө аж ахуйн тогтвортой хөгжилд хоршоодын оролцоо”, “Үндэсний холбооны дүрмийн өөрчлөлт”, “Хоршоодын залгамж халаа ба тогтвортой хөгжил” гэсэн 3 салбар хуралдаанаар хоршоодод тулгамдаж буй асуудлаа хэлэлцэн, цаашид баримтлах бодлого чиглэлээ тодорхойлсон уриалгыг гаргалаа. Зөвлөгөөний үеэр аймгуудын брэнд бүтээгдэхүүний үзэсгэлэн, тогооч нарын ур чадварын тэмцээн, ноосон хувцасны загварын үзүүлэн тоглолт болж, үзэсгэлэн худалдааны азтанг тодруулсан.

МХААХҮХ, Аймгийн Тогоочдын холбоотой хамтран “Ургацын далай” сэдэвт тогоочдын ур чадварын уралдааныг Партизины талбайд Сүхбаатар, Шаамар, Ерөө сумдын 10 гаруй тогоочдыг оролцуулан зохион байгуулж, 1-р байранд Сүхбаатар сумын 6-р сургуулийн тогооч Н.Болормаа, 2-р байранд Ерөө сумын “Ерөө бугант” хоршооны тогооч К.Энхцэцэг нар шалгарч, аймгийн тогоочдын ур чадварыг дээшлүүлэн харилцан туршлага судлуулсан арга хэмжээ боллоо.

Стандарт, хэмжил зүйн ажил үйлчилгээний талаар:

Тайлант сард Ерөө, Мандал, Орхонтуул сумдын 3 аж ахуйн нэгж, иргэний 1 баар, 2 хүнсний дэлгүүрийн үйлчилгээнд тохирлын үнэлгээ хийж, холбогдох стандартын шаардлага хангасан 3 үйлчилгээний газарт тохирлын гэрчилгээг 1-2 жилийн хугацаатай олгож, тохирлын гэрчилгээ хэрэглэх эрхийн хугацаа дууссан 8 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд тохирлын үнэлгээ хийж зөвлөмж өглөө.

Шаамар, Ерөө сумын 2 аж ахуйн нэгж иргэний 3 нэрийн бүтээгдэхүүнийг аймгийн МХГ-ын итгэмжлэгдсэн сорилтын лабораторит шинжлүүлж, баталгаажуулалтын шинжээчийн дүгнэлт гаргаж, стандартын салбар сангаас 5 аж ахуйн нэгж, байгууллага, иргэнийг 4 нэрийн 5 стандартаар хангаж, арга зүйн зөвлөгөө өгч, үйлчилгээ үзүүлсэн байна.

Мөн аймгийн төв Сүхбаатар сумын аж ахуйн нэгжийн 7 усны тоолуурыг баталгаажуулж, 1 усны тоолуурт шаардлага хангаагүй тул улсын шалгагчийн мэдэгдэл өгсөн. Механик хэмжлийн ээлжит бус баталгаажуулалтаар худалдаа, үйлчилгээний газрын 5 жинг шалган баталгаажуулж, “Хөтөл ЦШ” ХХК-ний 1 авто машины жин загварын туршилтанд ороогүй буюу Монгол Улсад ашиглах хэмжих хэрэгслийн бүртгэлд байхгүй тул үйл ажиллагаандаа ашиглахгүй байх тухай улсын шалгагчийн мэдэгдлийг хүргүүлж ажиллалаа.

Цахилгааны хэмжлийн төрлөөр Сүхбаатар сумын аж ахуйн нэгж байгууллага, иргэний нийт 64 тоолуурыг шалган баталгаажууллаа.

Онцгой байдлын газрын ажил үйлчилгээний талаар:

Энэ оны 07 дугаар сарын 17-ны өдөр их хэмжээний аадар бороо орсны улмаас Сэлэнгэ аймгийн төв Сүхбаатар сумын нутаг дэвсгэрт үер буусан. Монголын улаан загалмай нийгэмлэг, Олон улсын Улаан Загалмай, Улаан Хавирган Сар Нийгэмлэгүүдийн холбооноос үерт автсан 30 өрхөд тус бүр 240,000 мянган төгрөгийн бэлэн мөнгөний тусламжийг 7 дугаар сарын 25-ны өдөр олгосон. Мөн бэлэн мөнгөний тусламжинд хамрагдсан иргэдэд өнөөдөр гал тогооны ком, хөнжил, гудас, усны сав зэрэг эрүүл ахуйн багцын 2 дахь удаагийн тусламжийг 2018 оны 08 дугаар сарын 28-ны өдөр үзүүллээ. Мөн нийтийн эзэмшлийн зам талбайг халдваргүйжүүлэхэд шаардлагатай 12,0 сая төгрөгийн халдваргүйтгэлийн бодисыг “Дэлхийн зөн олон улсын байгууллага”-ын Сэлэнгэ салбар нэн даруй шийдвэрлэж өгсний дагуу Сүхбаатар сумын хэмжээнд бохирдсон талбайг Эрүүл мэндийн газар, ХХААГ-ын Мал эмнэлгийн алба, Онцгой байдлын газар, Мэргэжлийн хяналтын газар, Сүхбаатар сумын мэргэжилтнүүд хамтран ариутгалын ДУК машинаар 2018 оны 7-р сарын 27-31-ний өдрийг дуустал халдваргүйжүүллээ.

2018 оны 08 дугаар сарын 16-ны өдөр Хүдэр, Ерөө, Орхон, Сант, Жавхлант, Шаамар сумд, Дулаанхаан тосгоны хамтарсан багийн 47 гишүүдэд онцгой нөхцөл байдал үүссэн үед өөрийгөө болон ойр дотны хүмүүсээ авран хамгаалах дадал олгох,

мэдлэгийг бататгах, дадлага олгох зорилгоор "Мэдлэг амийг тань аварна" сэдэвт ажил хэрэгч тоглоомын аргаар сургалтыг зохион байгууллаа. Сургалтанд оролцогчдыг 2 багт хувааж, дотуур байрны нэг давхарын үүдэнд гал гарч эхэлснээр цагийн байдал өгч, хариу арга хэмжээг хэрхэн ямар үе шаттайгаар авах талаар гишүүд ярилцаж, ажилласан нь сургалт үр дүнтэй боллоо гэж оролцогчид дүгнэлээ.

Монгол Улсын Шадар сайдын баталсан "Газрын тос олборлодог газрын тосны бүтээгдэхүүн хадгалдаг, борлуулдаг аж ахуйн нэгж, байгууллагуудад гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын тухай хууль, стандарт, норм нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах төлөвлөгөөт хяналт шалгалтын удирдамж"-ийн хүрээнд 2018 оны 08 дугаар сарын 01-30-ны хооронд Сүхбаатар суманд үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага аж ахуйн нэгжийг хамруулан ажиллалаа.

Аймгийн Онцгой байдлын газар, Улаан Загалмай хороотой хамтран тус аймгийн Түшиг суманд 15 иргэний бүрэлдэхүүнтэй сайн дурын бүлгийг сумын Засаг даргын захирамжаар байгуулж, иргэдэд гамшгаас урьдчилан сэргийлэх мэдлэг олгох сургалтын танхим, гал түймэртэй тэмцэхэд шаардагдах багаж хэрэгсэл, усан хөөрөг, хөдөлмөр хамгаалалын хувцас зэргийг Улаан Загалмай хорооны хөрөнгө оруулалтаар шийдвэрлэн гардуулан өгч, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, гарсан гал түймрийг унтраах арга ажиллагааны талаар 2 цагийн танхимын сургалт, гал унтраах хөөргөн дээр ажиллах, гал унтраах дадлага сургуулийг тус тус зохион байгуулж анхан шатны мэдлэг олголоо. Мөн Түшиг Цагааннуур сумдын иргэдийн гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлаа хангах талаар мэдлэг олгох сургалтанд зориулж тус сумдын Засаг даргын тамгын газрын даргад бэлэн бай сургалтын гарын авлага бүхий 240 ш сэрэмжлүүлэг материалыг хүлээлгэн өглөө.

Хоёр. Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:

Төсвийн ерөнхийлэн захирагчийн 2018 оны эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланг сумд болон төсөвт байгууллагуудаас хуулийн хугацаанд Э-Тайлан цахим програмаар хянан хүлээн авч 2018 оны 08 дугаар сарын 13-ны өдөр нийт 193 байгууллагын санхүүгийн тайлангийн нэгтгэлийг хуулийн хугацаанд Сангийн яаманд хүргүүлсэн. 2018 оны эхний хагас жилийн байдлаар төсвийн гүйцэтгэл 38,5 тэр бум төгрөг буюу 81,9 хувийн гүйцэтгэлтэй нэгтгэгдлээ.

Төсөвт байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 236,3 сая төгрөг буюу 133,3 хувийн биелэлттэй, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн 2,2 тэр бум төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын 27,2 тэр бум төгрөг, орон нутгийн байгууллагын 12,2 тэр бум төгрөгийн санхүүжилтыг тус тус авсан байна. Өглөг авлагын хувьд оны эхний үлдэгдлээс авлага 0,8 сая төгрөг, өглөг 1,2 тэр бум төгрөгөөр тус тус өссөн нь орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын өглөг авлага нэмэгдсэнтэй холбоотой байна.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч, төвлөрүүлэн захирагчийн 2019 оны төсвийн төсөл, 2020-2021 оны төсөөллийг Монгол Улсын Засгийн газраас баталсан төсвийн хүрээний мэдэгдлийг үндэслэн боловсруулж, 08 дугаар сарын 15-21-ний өдрүүдэд Сангийн яаманд хянуулаад байна. Аймгийн төсвийн орлогыг 18,9 тэр бум төгрөг, төсвийн суурь зарлагыг 20,7 тэр бум төгрөгөөр тус тус хянууллаа. Төсвийн орлогын хувьд 2019 онд цалин нэмэгдэж байгаатай холбогдуулан цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогыг нэмэгдүүлэн тооцсон. Зарлагын хувьд томилолт болон шатахууны зардлыг шинэчилсэн тарифаар тооцоолж мөн тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын халаалтын зардлыг орон нутагт шилжүүлж байгаатай холбогдуулан зардлыг нэмэгдүүлэн тооцсон.

Өнгөрсөн сард 682 баримтаар 3 303,5 сая төгрөгийн төсөвт байгууллагуудын төлбөр тооцоог хянан гүйцэтгэж, давхардсан тоогоор 16 баримтаар төсөвт

байгууллагуудын нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулалтын эрхийн хүсэлтийг хүлээн авч 276.2 сая төгрөгийн зарцуулалтын эрхийг нээж ажиллалаа.

1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:

Д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1. Орон нутгийн төсвийн нийт орлого		49,173,507,8	48.053.141.1	97,7
1.1	Орон нутгийн төсвийн орлого	10.649.009.5	9.645.506.3	90,6
	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	8.020.461.8	6.774.995.1	84.5
	Сумдын төсвийн орлого	2.628.547.7	2.870.511.2	109.2
1.2	Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	4.300.000.0	4.300.000.0	100.0
1.3	Улсын төсвөөс олгох тусгай зориулалтын шилжүүлэг	28.731.883.5	28.731.883.5	100.0
1.4	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг	2.471.797.8	2.471.797.8	100.0
1.5	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн орлого/	1.470.930.6	2.761.970.3	187.8
1.6	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн хөгжлийн сан/	96.515.5	141.983.2	147.1
2. Орон нутгийн төсвийн нийт зарлага		49.173.507.8	42.841.148.2	87.1
2.1	Орон нутгийн төсвийн нийт зарлага	49.173.507.8	42.841.148.2	87.1
	Үүнээс: Сумдын орон нутгийн байгууллагуудын зарлага	6.859.635.3	5.557.912.4	81.0
	Сумдын орон нутгийн хөгжлийн сан	1.818.810.7	938.303.5	51.6
	Аймгийн шууд харьцдаг байгууллагуудын зарлага	11.686.010.2	9.224.129.3	78.9
	Үүнээс: Аймгийн төсвийн хөрөнгө оруулалт	2.430.510.0	967.135.6	39.8
	Аймгийн замын сангийн хөрөнгө оруулалт	400.000.0	186.458.3	46.6
	Аймгийн орон нутгийн хөгжлийн сан	741.581.4	775.962.6	104.6
	Халамжийн сан	5.342.183.2	4.989.675.7	93.4
	Шууд харьцдаг төсвийн байгууллагуудын зарлага	2.544.623.9	2.121.122.1	83.4
	Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө	227.111.7	183.775.0	80.9
	Сумдын тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага	27.064.233.2	25.564.548.0	94.5
	Аймгийн тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага	1.744.818.4	1.556.255.0	89.2
	3. Аймагас олгосон санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлэг		34.048.930.1	34.048.930.1
3.1	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	2.834.029.0	2.834.029.0	100.0
3.2	Сумдад олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	1.786.903.9	1.786.903.9	100.0
	Үүнээс: Хот тохижуулахын урсгал зардалд	76.608.7	76.608.7	100.0
	Мал эмнэлгийн үйлчилгээний зардалд	270.007.0	270.007.0	100.0
	Хөрөнгө оруулалтын зардалд	1.440.288.2	1.440.288.2	100.0
3.3	Аймагт олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	696.113.7	696.113.7	100.0
	Үүнээс: Хөрөнгө оруулалтын зардалд	693.387.2	693.387.2	100.0
	Мал эмнэлгийн үйлчилгээний хяналтын зардалд	2.726.5	2.726.5	100.0
3.4	Сумдад олгосон тусгай зориулалтын	27.017.040.6	27.017.040.6	100.0

	шилжүүлэг			
3.5	Аймагт олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	1.714.842.9	1.714.842.9	100.0
3.6	Тусгай зориулалтын шилжүүлэг /салбараар/	28.731.883.5	28.731.883.5	100.0
	- Ерөнхий боловсролын сургууль	15.021.298.4	15.021.298.4	100.0
	- Хүүхдийн цэцэрлэг	7.192.776.6	7.192.776.6	100.0
	- Соёлын байгууллага	1.884.280.1	1.884.280.1	100.0
	- Биеийн тамир спортын байгууллага	662.246.4	662.246.4	100.0
	- Эрүүл мэндийн байгууллага	3.516.592.0	3.516.592.0	100.0
	- Газрын кадастрын байгууллага	233.012.5	233.012.5	100.0
	- Хүүхдийн байгууллага	221.677.5	221.677.5	100.0
4. Тусгай сангуудын зарлага		937.099.9	254.625.4	27.2
4.1	Сумдын сум хөгжүүлэх сан	937.099.9	254.625.4	27.2

2.Өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн тухай:

Өргөн хэрэглээний барааны нэр төрөл		2018 VI- сар	2018 VII- сар	<u>2018- VII</u> <u>2018- VI</u> <u>/төгрөгөөр/</u>
1.ХҮНСНИЙ БАРАА				
1	ТАЛХ, ГУРИЛ, БУДАА			
	Гурил /савласан, кг/	1 100	1 100	100.0
	Талх /орон нутгийн, ш/	1 100	1 100	100.0
	Нарийн боов /кг/	2 500	2 500	100.0
	Будаа /кг/	2 400	2 400	100.0
	Элсэн чихэр /кг/	2 200	2 200	100.0
2	МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН			
	Хонины мах /кг/	6 500	6 500	100.0
	Үхрийн мах /кг/	7500	7 000	93.3
	Адууны мах /кг/	5800	6000	103,4
	Ямааны мах /кг/	5 500	5 000	90,9
	Дотор мах, цувдай /цусгүй/	3 500	3 500	100.0
	Хиам /чанасан, кг/	10 000	10 000	100.0
3	СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ			
	Сүү /задгай, л/	800	800	100.0
	Сүү / савласан, л/	2 600	2 600	100.0
	Тараг /задгай, л/	1 000	1 000	100,0
	Хорхой ааруул /задгай, чихэртэй, кг/	13 000	13 000	100.0
	Айраг /л/	3 500	3 500	100.0
	Хуурай сүү /кг, Орос, 25% тослогтой/	4 500	4 500	100.0
	Өндөг /ш/	350	350	100.0
4	БҮХ ТӨРЛИЙН ӨӨХ ТОС			
	Ургамлын тос /л/	3 800	3 800	100.0
	Өөхөн тос /кг/	2000	2 000	100.0
	Шар тос /кг/	13 000	13 000	100.0
	Масло /задгай, кг/	4 500	4 500	100.0
5	ХҮНСНИЙ НОГОО			
	Төмс /кг/	1 200	1 200	100.0
	Лууван /кг/	1 200	1200	100.0
	Манжин /кг/	1 500	1 500	100.0

	Байцаа /кг/	1 500	2000	133,3
	Сонгино /кг/	1 500	2000	133,3
	Өргөст хэмх /шилтэй, дарсан/	3 500	3 500	100.0
	Алаг салат /шилтэй, Urbanek, 630гр/	2 300	2 300	100.0
7	ШАТАХУУН			
	Бензин А - 80	1 645	1 645	100.0
	Бензин А - 92	1 800	1 800	100.0
	Дизелийн түлш	2 105	2 105	100.0

Гурав.Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

Тайлант сард Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх болон Хүүхэд хамгаалах талаарх 2 удаагийн сургалтыг 6 сум, 2 тосгоны төрийн албан хаагч, иргэдийг хамруулан “Дэлхийн зөн” ОУ-ын байгууллагын санхүүгийн дэмжлэгээр холбогдох газруудтай хамтран зохион байгуулсан.

Архивын Ерөнхий газартай байгуулсан санамж бичгийн хүрээнд Архивын зориулалтын байр барихад дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах ажлын хүрээнд Архивын Ерөнхий газраас Архивын барилгын нэг загварын зураг болон зөвлөмжийг ирүүлсэн. Энэ ажлын хүрээнд байр барих бэлтгэл ажлыг хангаж газрын асуудлыг аймгийн Засаг даргын захирамжаар шийдвэрлүүлээд байна.

Шударга, өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газраас ирүүлсэн тоотын дагуу Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөрийн 2 жилийн тайлан болон 2018 оны 9-р сарын 20-ны өдөр зохион байгуулагдах үндэсний анхдугаар зөвлөгөөнд оролцох аймгийн бүрэлдэхүүний нэрсийг тус тус гаргаж хүргүүлэхээр ажиллаж байна. Үндэсний зөвлөгөөнийг угтаж сумдад сумын анхдугаар зөвлөгөөн зохион байгуулах тухай аймгийн Засаг даргын захирамж, албан тоотыг хүргүүлсэн.

2018 оны 07 дугаар сард 257 холбогдогчтой, 654,9 сая төгрөгийн хохиролтой, 422 гэмт хэрэг бүртгэгдэж, 4 хэргээр буюу 0,1 хувиар урьд оны мөн үеэс өсч, гэмт хэргийн илрүүлэлт 39,5 хувьтай байна. 2018 оны 07 дугаар сард 11538 зөрчлийг илрүүлэн шалгаж шийдвэрлэсэн нь 1775 зөрчлөөр буюу урьд оны мөн үеэс 13,3 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Улсын бүртгэлийн хэлтсээс 08 дугаар сард газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ 332 бичиж, лавлагаа 16, газраас бусад үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийн гэрчилгээ 127, лавлагаа 24 олгож үйлчиллээ. Иргэний бүртгэлийн чиглэлээр төрсний бүртгэл – 178 /эрэгтэй-87, эмэгтэй-82/, гэрлэлтийн бүртгэл – 20, гэрлэлт цуцалсны бүртгэл – 8, үрчлэлт – 2, эцэг тогтоолт – 62, овог эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл – 6, нас баралт – 52, олгосон иргэний үнэмлэх – 617, гадаад паспорт олголт – 68, аймаг хот руу бүр мөсөн шилжин явсан – 322, аймаг хотоос бүр мөсөн шилжин ирсэн – 195, хот доторх шилжилт хөдөлгөөн – 669 тус тус бүртгэгдсэн байна.

Дөрөв.Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:

1.Боловсрол, соёл урлаг, спортын чиглэлээр:

Боловсрол соёл шинжлэх ухаан спортын дэд сайдаар ахлуулсан ажлын хэсэг 2018 оны 07 дугаар сарын 30-ны өдөр тус аймагт ажиллаж, боловсрол, соёл урлаг, спортын байгууллагуудын үйл ажиллагаатай танилцсан.

Ерөнхий боловсролын сургуулийн XII ангийн STEM боловсролын сургалтанд дэмжлэг үзүүлэх сургалтыг 2018 оны 08 дугаар сарын 20-22-ны өдрүүдэд 12 дугаар сургалттай ерөнхий боловсролын 17 сургуулийн хими, математик, дизайн технологи, физикийн нийт 296 багшид зохион байгуулан, “Бүрэн дунд боловсролын XII ангийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй” сургалтын модуль III-ыг багш бүрт олгосон.

“Бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй-III” сургуулийн менежмент үндэсний сургалтад 2018 оны 08 дугаар сарын 20-22-ны өдрүүдэд Улаанбаатар хотод хамрагдаж, 9 мэргэжилтэн орон нутгийн сургагч багшаар бэлтгэгдсэн.

2018 оны 08 дугаар сарын 20-22, 25-26-ны өдрүүдэд математик, физик, хими, дизайн технологи, монгол хэл бичиг уран зохиол, мэдээллийн технологи, газар зүй, биеийн тамир, орос хэл, англи хэл, биологи, түүх нийгмийн ухааны багш нар, сургуулийн захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтан, бага, дунд ангид эрүүл мэндийн хичээл заах багш, 1 дүгээр ангид хичээл заах нийт 800 гаруй багшийг сургалтад хамруулж, мэдлэг, заах арга, ур чадварыг дээшлүүлэн ажилласан.

Эрүүл мэндийн яам, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвөөс гаргасан цэцэрлэг, бага дунд анги, ахлах ангийн сурагчдад зориулсан “Хуванцар савны хэрэглээ” сэдэвт зурагт хуудасыг сургууль, цэцэрлэгт тараан хүргүүлж, хуванцар савны хэрэглээний талаар цэцэрлэгийн хүүхэд, сургуулийн сурагч болон эцэг эхчүүдэд мэдээлэл өгөх талаар сургууль, цэцэрлэг анхаарч ажиллах талаар зөвлөмж хүргүүлсэн.

2018 оны 08 дугаар сарын 27-нд цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, сургуулийн захирал, сургалтын менежер, сургууль бүрээс 3 багш нийт 280 гаруй багшийг хамруулсан багш нарын бага хурлыг зохион байгуулж 2017-2018 оны хичээлийн жилийн ололт, амжилт, шинэ хичээлийн жилийн зорилго, зорилт, сургалтын чанар өнөөгийн байдал, цаашид анхаарах асуудлууд, элсэлтийн ерөнхий шалгалтын дүн, анхаарах зүйлүүд, багш, удирдах ажилтнуудын санал, хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэх зүйлүүдийн талаар хэлэлцсэн.

2018-2019 оны хичээлийн жилд хэрэглэгдэх 5-р ангийн математик 1768, дүрслэх урлаг, технологи 945, хөгжим 1266, иргэний боловсрол 1266, 4-р ангийн хүн байгаль 1437, монгол хэл 1437, 1-р ангийн бэлтгэл хөтөлбөр 2368, хөгжим 830, иргэний боловсрол 2368, 2-р ангийн математик 1159, монгол хэл 1159, хүн орчин 1159, дүрслэх урлаг, технологи 1159, 4-р ангийн математик 1437, дүрслэх урлаг, технологи 1437 нийт 21195 ширхэг сурах бичгийн БСШУСЯ-аас ирүүлсэн хуваарийн дагуу хэвлэлийн компаниудаас хүлээн авч ерөнхий боловсролын сургуулиудад хүргүүлээд байна.

БСШУСЯ-аас зохион байгуулсан Соёлын биет бус өвийн их наадам, “Нүүдэлчин Монгол наадам” 2018 оны 8 дугаар сарын 10-13-ны өдрүүдэд Улаанбаатар хотод “Хүй долоон худаг”-т зохион байгуулагдаж тус наадамд 21 аймаг, 9 дүүрэг оролцсон.

Аймгийн Засаг дарга Ш.Оргилын санаачлагаар түүхийн дурсгалт газрыг сурталчилах, сэргээх, өв уламжлан хамгаалах зорилгоор “Буур хээрийн тойром” шагайн харвааны нээлттэй тэмцээнийг зохион байгуулж Дархан, Төв, Дорноговь, Булган, Улаанбаатар хот, Сэлэнгэ аймгийн 9 сум 1 тосгоны нийт 28 багийн 225 туршлагтай өндөр цол зэрэгтэй дархан мэргэчүүд, харваачид оролцож тэргүүн байранд Булган аймгийн Үлэмж дархан мэргэн Ч.Түвшинжаргал ахлагчтай баг 2 дугаар байранд дархан мэргэн Б.Батбаатар, Ж.Гансуурь ахлагчтай Сэлэнгэ аймгийн Хөтөл, Орхонтуул сумын баг тамирчид шалгарсан. Хүн нэг бүрийн цуваа харваанд нийт 114 тамирчид цэц мэргэнээ сорин уралдаж Сэлэнгэ аймгийн Мандал сумын залуу харваач А.Итгэл түрүүлэн, Улаанбаатар хотын харваач С.Жаалай, Дорноговь аймгийн харваач А.Доржсүрэн удаалсан.

Үндэсний спортын их наадамд халх сур, буриад сур, урайнхан сур, Уламжлалт харваа, үндэсний бөх, шагайн харваа, уран уургач бугуйлч, шагай шүүрэх, шагай няслах морь уралдуулах, жороо морь, гэсэн спортын 10 төрөлд Сэлэнгэ аймгаас 60 тамирчин оролцож Үндэсний бөхийн багийн барилдаанд 3-р байр хүрэл медаль, жороо морины уралдаанд 2-р байр эзлэн мөнгөн медаль хүртсэн амжилт үзүүллээ. Улсын их хурлын гишүүн Н.Оюундарийн санаачлагаар Биеийн тамир спортыг иргэн, айл өрх бүрт хүргэх зорилгоор “Иргэдийн спортын анхдугаар наадам”-ыг 5 сум 1 тосгоныг хамруулан спортын 6 төрлөөр явуулж 581 иргэд тамирчид оролцож эхний

байранд багаараа Алтанбулаг сум, 2 дугаар байранд Ерөө сум, 3 дугаар байранд Сүхбаатар сумын 2 багийн тамирчид удаалсан.

2.Эрүүл мэндийн талаар:

Эрүүл мэндийн сайдын 2010 оны 224 дүгээр тушаалыг хэрэгжүүлэх, үйл ажиллагааг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулж салбарын мэргэжилтэнд төрөлжсөн мэргэжлийн тусламж үйлчилгээ үзүүлэх үзлэгийн карт нээж эмчилгээнд хамруулсан. Эрүүл мэндийн салбарын 407 ажиллагсдыг хэвтүүлэн эмчилж, 10 ажилтанд хөдөлгөөн засал эмчилгээ, 356 эмч ажиллагсдад хоолойн санац хийж, зөв хооллолт, хүзүү нурууны дасгал зааж, сургасан.

Монгол улсын Ерөнхий сайдын 2018 оны 105 дугаар захирамжийн дагуу Эрүүл мэндийн яам, Глобаль сангийн дэмжлэгтэйгээр Монголын өрхийн анагаах ухааны мэргэжилтнүүдийн холбоотой хамтран “Сүрьеэгүй аймаг” олон талын оролцоог хангах ухуулга, нөлөөллийн уулзалт, хэлэлцүүлэг, сүрьеэгийн тусламж үйлчилгээг зохицуулагч бэлтгэх сургалтыг 2018 оны 08 сарын 07-08 өдрүүдэд зохион байгуулан удирдах албан тушаалтан, эмч, сүрьеэгийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийн нийт 70 хүн хамрагдсан.

Эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Хилийн мэргэжлийн хяналтын алба, Мал эмнэлгийн алба, аймгийн Барилга хот байгуулалтын газар, Сүхбаатар сумын Засаг даргын Тамгын газрын мэргэжилтнүүд, улсын байцаагч нарын хамтарсан ажлын хэсэг байгуулагдаж үерийн улмаас бохирлогдсон гудамж талбай, голомтын бүс тогтоох зорилгоор хими, нян судлалын шинжилгээнд хөрснөөс нийт 18 дээж авч Мэргэжлийн хяналтын газрын итгэмжлэгдсэн лабораторид шинжилсэн. Үер усны гамшгийн дараах 3 хоногийн хугацаанд аймгийн Эрүүл мэндийн албанаас томилогдсон 29 хүний бүрэлдэхүүнтэй хамтарсан баг бохир хальсан 44 айлын хашаа болон нийтийн эзэмшлийн талбай болох бүх орон сууц давхар байрнуудын орц, БСУГ, 4-р цэцэрлэг зэрэг газруудын нийт 4000 м² талбайд халдваргүйтгэлийн ажлыг хийж нэг удаагийн өмсгөл, халдваргүйтгэлийн бодис, шатахуун зэрэгт 1007160 төгрөг зарцуулагдсан байна. Үерийн дараах үед халдвараас сэргийлэх мэдээлэл, зөвлөмжийг орон нутгийн 2 телевиз, 2 сонин, халдвараас сэргийлэх 4 төрлийн 850 ш зөвлөмж гарын авлага иргэдэд тарааж, олон нийтийн газруудад 5 төрлийн зөвлөмжийг байршуулсан.

Сүхбаатар сумын олон нийтийн сүлжээгээр иргэдэд хандсан 6 төрлийн зөвлөмж, мэдээллийг тухай бүрт нь өгч ажилласан. Бүгд найрамдах Герман улсын “Хил хязгааргүй шүдний эмч нар”-ын 45 хүний бүрэлдэнхүүнтэй баг 14 хоногийн хугацаанд нийт 6 сум 3 тосгоны 8000 гаруй хүнд үнэ төлбөргүй амны хөндийн үзлэг хийн, эрүүлжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулсан.

Тусгай зөвшөөрлийн 3 дугаар улирлын хуралд 16 байгууллагын материалыг хүлээн авч хэлэлцээд, шаардлага хангаагүй 3 байгууллагад зөвлөгөө өгч, материалыг буцаасан.

3.Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн талаар:

“Тогтвортой хөгжлийн боловсрол” төслийн хүрээнд байгаль дахь сургалтын төвийг Шаамар сумын 1 дүгээр баг “усан сангийн дэнж” гэдэг газар 4 өртөө байгуулах бэлтгэл ажлыг ханган ажиллаж 9 дүгээр сард нээлтийн арга хэмжээг зохион байгуулна.

Хүүхдийн тусламжийн 108 утасанд нийт 10 дуудлага ирсэнээс сэтгэл санааны дарамт 5, бие махбодын хүчирхийлэл 3, эдийн засгийн хүчирхийлэл 1, нас барсан 1 дуудлага ирж хамтарсан багийн хариу үйлчилгээ үзүүлж байна.

4.Хөдөлмөр, нийгмийн халамжийн үйлчилгээний талаар:

2018 оны 07-р сарын байдлаар бүртгэлтэй ажилгүй иргэд 811 байсан бол 82 иргэн шинээр бүртгүүлж ажил олгогчоос ирүүлсэн 28 ажлын байранд 20 хүнийг ажилд

зуучилж, идэвхигүйн улмаас 78 иргэн хасагдаж бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 795 болсон байна.

Нийгмийн халамжийн сангаас 08 сарын байдлаар 38086 иргэнд 9.195.404.0 мянган төгрөгийг олгоод байна. Үүнд:

-Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2545 иргэнд 2.821.884.8 мянган төгрөг

-Нийгмийн халамжийн нөхцөлт мөнгөн тэтгэмж 1643 иргэнд 777.479.7 мянган төгрөг

-Амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж 1581 иргэнд 609.462.3 мянган төгрөг

-Ахмад настны тусламж, хөнгөлөлт 3735 иргэнд 376.314.6 мянган төгрөг

-Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгож буй тусламж хөнгөлөлт 392 иргэнд 107,623,3 мянган төгрөг

-Жирэмсэн эхийн тэтгэмж 1839 эхэд 264.682.7 төгрөг

-Алдар цолтой ахмад настанд үзүүлэх тусламж хөнгөлөлт 42 иргэнд 58.737.1 мянган төгрөг

-Эхийн алдар одонтой эхчүүдийн хөнгөлөлт тусламжинд 8457 иргэнд 1,131.620.0 мянган төгрөг

-Насны хишиг 4507 иргэнд 674,870,0 төгрөг

-Цалинтай ээж хөтөлбөр 5883 иргэнд 1.737.787.3 мянган төгрөг

-Өрх толгойлсон эх, эцэг хөтөлбөр 172 иргэнд 73,760.0 мянган төгрөг

-Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ 107 иргэнд 14,352,0 мянган төгрөг

-Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ 7030 иргэд 528.230.7 мянган төгрөг

5.Нийгмийн даатгалын ажил үйлчилгээний талаар:

2018 оны 07 сарын байдлаар 18.5 тэр бум төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөтөйгээс 07 сарын 31-ний байдлаар өссөн дүнгээр 19.5 тэр бум төгрөгний орлого төвлөрүүлж 105.47 хувийн биелэлттэй ажиллаж байна.

Тэтгэврийн даатгалын сангаас 16210 тэтгэвэр авагчдад 35.9 тэрбум төгрөгийг тэтгэвэрт, Тэтгэмжийн даатгалын сангаас 4213 хүнд 1557.81 сая төгрөгийг, Хөдөлмөрийн чадвараа түр алдсан, Жирэмсэн амаржсан, оршуулгын тэтгэмжид, Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас үйлдвэрийн ослын тэтгэвэр, хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж, нөхөн төлбөр, сувиллын зардалд 291 хүнд 683,96 сая төгрөг, Ажилгүйдлийн даатгалын сангаас 298 хүнд 394,45 сая төгрөгийг ажилгүйдлийн тэтгэмжид тус тус олгосон.

Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагааг 08 сард 297 иргэд, даатгуулагчдад гаргасан.

Эрүүл мэндийн даатгалын орлогод энэ жил 417 сая төгрөг оруулах төлөвлөгөөтэйгөөс эхний 6 сарын байдлаар 296 сая төгрөгийг оруулсан 142,1 хувийн биелэлттэй байна. Эрүүл мэндийн хамрагдалтанд малчин, ажил хөдөлмөр эрхлээгүй иргэд, оюутан суралцагсад нийт 12400 иргэнийг хамруулах төлөвлөгөөтэйгөөс 7462 иргэнийг хамруулж, 124 хувийн биелэлттэй ажиллаж байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас эмнэлэг, эмийн сангуудад 2,5 тэр бум төгрөгийн зардлыг тус тус хянаж олгосон байна.

Эрүүл мэндийн даатгалын чиглэлээр энэ онд Улсын 3 эмнэлэг, хувийн хэвшлийн 6 эмнэлэг, 30 эмийн сантай гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд энэ жилээс эхлэн өрх сумын Эрүүл мэндийн төвтэй гэрээ байгуулан ажиллаж эхэлсэн ба тус аймгаас Жавхлант сумын Эрүүл мэндийн төв сонгогдон 9 сард ажлаа эхлэхээр болсон.

Нийгмийн даатгалын шимтгэлийн өр, авлага 07 дугаар сарын байдлаар 8,3 тэр бум бөгөөд нийт өрийн 80 хувийг Сайхан сумын Хөтөлийн “Цемент шохой” ХХК 4,7 тэр бум, Сайхан сумын “Гавшгай ус” ХХК 730,0 сая, Сүхбаатар сумын “Урсгал-ус” ОНӨААТҮГазар 563,5 сая, “Сэлэнгэ энерго” ОНӨААТҮГ 392,3 сая төгрөгний шимтгэлийн өртэй дээрхи аж ахуйн нэгжүүд эзлэж байна. Эдгээр өр авлагыг

барагдуулахаар ерөнхий газар, шүүх болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх газартай шат дараалсан арга хэмжээ авч хамтран ажиллаж байна.

Нийгмийн даатгалын Ерөнхий газраас энэ сард Хяналт шалгалт, дотоод аудит мониторинг, хүний нөөцийн чиглэлээр хяналт шалгалт хийж зөвлөгөө, чиглэл өгснийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тав.Үйлдвэр, хөдөө аж, ахуйн бодлогын хүрээнд:

“Төв хангайн бүсийн хоол үйлдвэрлэл, үйчилгээний салбарын арга хэмжээ” 08 дугаар сарын 22-26-ны өдрүүдэд Булган аймагт болсон бөгөөд арга хэмжээнд Ерөө, Цагааннуур, Сүхбаатар, Мандал, Хүдэр, Баруунбүрэн, Сайхан, Шаамар сумдын 15 тогоочид оролцож, спортын арга хэмжээнд багаараа “Гуравдугаар байр”, урлагийн арга хэмжээнд “Тусгай байр” эзэлсэн. Мөн “Төв хангай бүсийн тогоочдын ур чадварын уралдаан”-д “Ресторан, зоогийн газар, кафен төрөлд Цагааннуур сумын “Хангай” цайны газрын тогооч Н.Отгонбаяр “Алтан медаль”, Сайхан сумын ЕБС-ийн тогооч Угтахбаяр “Тусгай байр”, Цэцэрлэг, сургуулийн хоолны төрөлд Сайхан сумын ЕБС-ийн тогооч Ц.Нямаа “Алтан медаль”, “Шилдэг багийн Гранпри”-д Сүхбаатар сумын 1-р сургуулийн тогооч Э.Тунгалаг ахлагчтай баг “Тусгай байр” эзэлж, амжилттай оролцсон.

Орон нутгийн онцлогтой хоол, сүү цагаан идээ, хүнсний ногоо, нарийн боовны өдөрлөг, үзэсгэлэн худалдаанд Сэлэнгэ аймаг "хоёрдугаар" байр эзэлж, аймгийнхаа брэнд хоолуудыг сурталчиллаа.

Хүнс, хөдөө аж ахуйн, хөнгөн үйлдвэрийн яам сүүний чиглэлийн үхэр үржүүлж буй аж ахуйн нэгжүүдэд зээлийн дэмжлэг үзүүлэх төсөл шалгаруулалтаар Алтанбулаг сум “Хүрэн талын эх ХХК”, Алтанбулаг сум, “Энхсүрэг үнээний фермер”, Алтанбулаг сум “Бага цоорхой хоршоо”, Сүхбаатар сум “Арбахамын хүүхдүүд ХХК”, Сүхбаатар сум “Чоносбүргэд ХХК,” Түшиг сум “Ерөө гол өөд ХХК”, дэмжих бичиг авч төслийн сонгон шалгаруулалтанд орсон.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Орхон, Шаамар, Алтанбулаг, Сайхан, Цагааннуур сумдад бэлчээрийн усан хангамжийг сайжруулах инженерийн хийцтэй худаг шинээр барьж байгуулах ажлын гэрээг ХХААХҮЯ-ны төрийн нарийн бичгийн даргатай “Булган ус” ХХК нь гэрээ байгуулж, ажлыг эхлүүлээд байна.

Шүлхий өвчнийг улсын хэмжээнд нэгэн зэрэг илрүүлэх эмнэл зүйн болон ийлдэс судлалын тандалтыг Мандал, Баянгол, Орхонтуул, Ерөө, Түшиг суманд зохион байгуулж нэг суманд 3 баг 16 малчин өрхийг хамруулж, өрх бүрээс 5 үхэр, 5 хонь, нийт 800 гаруй малын цусанд ийлдсэнд шүлхийн эсрэг биет илрүүлэх ЭЛИЗА шинжилгээний аргаа ршинжилж халдварлалтгүй болохыг тогтоон ажиллалаа.

Зургаа. Хөрөнгө оруулалт, газрын харилцааны хүрээнд:

Газрын мэдээллийн сангийн ЛМ программ хангамжид 17 сумын газрын төлбөрийн мэдээллийг нөхөн оруулж хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж байна.

Банк болон банк санхүүгийн байгууллагад газар эзэмших эрхийн гэрчилгээгэ барьцаалан зээл авч байгаа 20 иргэн аж ахуйн нэгжийн газар эзэмших эрхийн барьцааны бүртгэлийг газрын цахим биржид бүртгэлжүүлэн 15 иргэн аж ахуйн нэгжийн барьцааг чөлөөлж газрын мэдээлийн санд холбон ажилласан.

Сэлэнгэ аймгийн Бэлчээр ашиглагчдын холбооны гүйцэтгэх захирал Л.Амарсайхантай хамтран 2018 оны 08 дугаар сарын 9-ний өдрөөс эхлэн 3 хоногийн хугацаатай Орхон, Сант, Орхонтуул сумдад бэлчээрийн фотомониторинг, бэлчээр ашиглалтын хэсгийн талаар сургалт зохион байгуулан ажилласан. Мөн бэлчээрийн төлөв байдал, түүний өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх ажлыг хүрээнд 2018 оны 08 дугаар сарын эхний 10 хоногт хээрийн судалгааны ажлыг хийж гүйцэтгэлээ. Аймгийн нийт сумдын хэмжээнд 89 мониторингийн цэгээс дээж авч, ургамлын бүрхэцийг тодорхойлон гаргасан.

Мөн Швейцарийн хөгжлийн агентлаг Ногоон алт төсөлтэй хамтран “Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх” чиглэлийн сургалтыг 17 сумын газрын даамлуудын дунд зохион байгуулав. Уг сургалтаар бэлчээрийн ургамлыг таних, түүнийг аж ахуйн бүлгээр ангилах, Sample point програм ашиглан 2018 оны мониторингийн судалгааны мэдээллийг боловсруулан түүний үр дүнг газрын кадастрын “Лэнд менежер” програм хангамж дээр мэдээллийг бүртгэж, бэлчээрийн даац, сэргэх чадавхи, үнэлгээг тооцоолж, тайлан мэдээг гаргалаа.

2018 оны 07 дугаар сарын 31-ний өдөр БСШУСЯамны дэд сайд тус аймгийн Сүхбаатар, Шаамар, Мандал сумдад боловсролын салбарт хийгдсэн бүтээн байгуулалтын доорх ажлуудтай танилцлаа. Үүнд: Сүхбаатар суманд баригдсан Усан бассейны барилга, 4–р цэцэрлэг, лаборатори 4 –р 12 жилийн сургуулийн барилга, Шаамар сумын Дулаанхаан тосгоны “75 ортой цэцэрлэг”-ийн барилга, Соёлын төв, 12 жилийн сургуулийн барилга, Мандал суманд баригдсан “560–н суудалтай сургуулийн барилга, 3–р сургууль, “Мөнгөн хараа чуулга”-ын барилгуудаар орж барилга байгууламжийн одоогийн байдалтай танилцан, ажлын бүрэлдэхүүнд холбогдох үүрэг даалгаврыг өгч ажилласан.

Долоо. Байгаль орчин, аялал жуулчлалын хүрээнд

Аймаг, орон нутгаа сурталчлах зорилгоор “Гонгорын бумбаны их тахилга”-ын арга хэмжээг Баруунбүрэн сумын Засаг даргын Тамгын газар, Амарбаясгалант хийдийн захиргаатай хамтран зохион байгууллаа. Арга хэмжээний үеэр Байгаль орчны тухай хууль, Хог хаягдлын тухай хууль, Усны тухай хууль, Аялал жуулчлалын тухай хуулийн хэрэгжилтийг хангаан Сэлэнгэ аймгийн хөтөч ном 20 ширхэг, түүх, дурсгал, байгалийн үзэсгэлэнт газруудыг үзэхэд зориулсан аялалын газрын зураг 50 ширхэг, “Гонгорын бумбаны их тахилга” санамж хуудас 2000 ширхэг тус тус бэлтгэн бумбаны хурлын үеэр сүсэгтэн олон, орон нутгийн иргэдэд тарааж, мэдээллээр хангаж ажиллалаа.

Ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөлүүдийн ойн менежмент төлөвлөгөөг хянаж менежмент төлөвлөгөө дуусан нөхөрлөлүүдэд хариутай албан бичиг төлөвлөж сумын болон сум дундын Ойн ангиудад хүргүүлсэн. Баруунбүрэн, Сант сумдуудад ажиллаж ойн нөхөрлөлүүдэд үнэлгээ хийх, түвшин тогтоох сургалт зохион байгуулсан. Энэ үеэр ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөлүүдэд нутгийн иргэдийг түшиглэсэн аялал жуулчлалын тухай мэдээлэл өгч, “Тогтвортой аялал жуулчлал ба Хүртээмжит эдийн засаг” төслийн танилцуулгыг хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.

Сэлэнгэ аймаг дахь Төрийн Аудитын газраас хийсэн “Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн орлогын бүрдүүлэлтийн үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитаар сумын болон сум дундын Ойн анги, байгаль хамгаалагч нартай холбогдолтой зөрчил дутагдал илэрсэн. Иймд гүйцэтгэлийн аудитын мөрөөр хийх ажлын төлөвлөгөөг газрын даргаар батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.

Мөн сумын болон сум дундын Ойн ангийн дарга, инженер техникч, нягтлан зарим сумдын байгаль хамгаалагчдыг хамруулан “Ойн тухай хуулийн хэрэгжилт, цаашид анхаарах асуудлууд” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулсан. Хэлэлцүүлэгч нийт 20 хүн оролцсон. Хэлэлцүүлгээс “Ойн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, давтан аудитад дээрх зөрчил дутагдалыг дахин гаргахгүй байх талаар үүрэг даалгавар өгч, мөрдөж ажиллах зөвлөмжийг гаргасан.

Найм.Сум орон нутгийн талаар

Алтанбулаг сум:

2018 оны ургац тогтоолтын ажлыг хугацаанд нь зохион байгууллаа. Ургацын урьдчилсан тогтоолтоор 1 га-гаас 13,9 цент ургац авахаар байна.

2018-2019 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах тухай аймгийн Засаг даргын албан даалгаврын дагуу төлөвлөгөө гарган ажиллаж хадлангийн гэрээг

112 малчин, мал бүхий иргэдтэй багуулж, хадлан тэжээлийн бэлтгэл сумын днгээр 20 гаруй хувьтай явагдаж байна.

2018-2019 оны хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажлын хүрээнд сумын цэцэрлэгийн барилгын их засварын ажлыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж энэ сарын 03-ны өдөр улсын комисс хүлээн авсан.

Алтанбулаг сумын уугуул Олон Улсын шатрын холбооны их мастер А.Энхтуул сумын цэцэрлэгт тоглоом бэлэглэж, цэцэрлэгийн гадна байрлах тоглоомын талбайн тоглоомуудыг сумын оюутан залуучуудтай хамтарч будаж, хашаан доторх зэрлэгээ зулгааж, хог хаягдлаа цэвэрлэсэн.

2018–2019 оны хичээлийн жилд цэцэрлэгт хамрагдах хүүхдүүдийн бүртгэлийг 8 сарын 20-ны өдрөөс эхлэсэн.

Эхийн сүүгээр хооллолтыг дэмжих дэлхийн долоо хоногийг “Эхийн сүү-амьдарлын үндэс” уриан дор тэмдэглэн өнгөрүүлэх ажлын төлөвлөгөөг гаргаж “Эрт амлуулалт ангир уураг” сэдэвт сургалтыг 18 жирэмсэн эхчүүдэд сурталчилж эрүүл мэндийн боловсрол олгосон. Мөн сумын ЭМТ-ийн 18 ажилчдад “Эхийн сүүний ач холбогдол”, “Нялх балчир хүүхдийн хүнсний хэрэглээний тухай” сэдэвт сургалтыг явуулсан. ЭМТ, ЗДТГ –ны банкуудын мэдээллийн самбар болон олон нийтийн цахим сүлжээгээр 3 төрлийн плакад 12 ширхэг, 14 төрлийн гарын авлагыг байршуулж сурталчилсан. Амбулаториор үйлчлүүлсэн 140 гаруй иргэдэд 3 төрлийн гарын авлага тараасан.

Монгол Улсын Их Хурлын гишүүн Наваан-Юндэнгийн Оюундарийн нэрэмжит Сэлэнгэ аймгийн 5 сум 7 багийн дунд зохион байгуулсан иргэдийн спортын андугаар наадам 2018 оны 08-р сарын 18,19-ний өдрүүдэд Сэлэнгэ аймгийн спортын ордон, спортын сургууль, 3-р сургуулиудад амжилттай зохион байгуулагдлаа. Тус тэмцээнд Алтанбулаг сум 93 иргэдийн бүрэлдэхүүнтэйгээр тэмцээний төрөл бүрт оролцож, явган аяллын баг цом алтан медаль, мөнгөн шагналаар, олс таталтын эрэгтэй, эмэгтэйбаг тамирчид тус бүр алтан медаль, цом мөнгөн шагналаар, эмэгтэй сагсан бөмбөгийн баг тамирчид мөнгөн медаль, мөнгөн шагналаар, эмэгтэй ширээний шагайн наадгайн шагайчид хүрэл медаль мөнгөн шагнал хүртсэн амжилтаар манай сум нийлбэр дүнгээрээ тэргүүн байрээлж шилжин явах цом мөнгөн шагналаар шагнууллаа.

Баруунбүрэн сум:

Энэ онд 9316 га талбайд үр тариа, 310 га талбайд тэжээлийн ургамал, 1764 га талбайд рапс, 90 га талбайд төмс, 78,94 га талбайд хүнсний ногоо тариалсан. Тариалалтын үед нөөц чийгтэй байсан боловч ургалтын хугацаанд гандалт болж орой бороо орсонтой холбогдуулан тарианы болц орой подгон түрж ургасан байдалтай байна. Сумын Засаг даргын захирамжаар ажлын хэсэг томилогдон ажиллаж, аж ахуй нэгж, иргэдийн талбайгаар тойрч ургацын урьдчилсан балансыг гаргахад сумын хэмжээнд 7485 га талбайгаас 7837 тонн үр тариа хураан авахаар байна. Ургацын байдал сумын дүнгээр оройтох төлөвтэй, зарим талбайд подгон их түрсэн, болц оройтож сүүн болцтой байна.

Мал төллөлтийн хувьд сумын хэмжээнд нийт 62841 хээлтэгч төллөснөөс ингэ 3, гүү 1871, үнээ 4350, эм хонь 35055, эм ямаа 20662 толгой байна. Нийт 62841 төл гарснаас ботго 3, унага 1871, тугал 4350, хурга 35055, ишиг 20662 төл гарсан байна.Төлийн хорогдол нийт 2637 байгаагаас унага 235, тугал 318, хурга 1080, ишиг 1004 хорогдсон байна. Мал төллөлтийн мэдээгээр төллөх гүүний 60 хувь, үнээний 65 хувь, эм хонины 85 хувь, эм ямааны 84 хувь нь төллөсөн.

Тус сумын 1,2,3 дугаар багийн 120 малчин өрхүүдэд малын гоц халдварт, халдварт, зооноз өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж, анхааруулга, сэрэмжлүүлэг, малын генетик нөөцийн тухай, мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн гарын авлага материал бэлтгэн тарааж, мал амьтны гоц халдварт, халдварт өвчин гарах, тархах эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор угаалга, халдваргүйжүүлэлтийн ажил зохион байгуулах тухай сумын Засаг даргын захирамж гаргуулан гоц халдварт,

халдварт, паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх бог малын угаалганд Батцэнгүүн мал эмнэлэг, үржлийн нэгж Шивээтийн мал угаалгын ваннд 11 өрхийн 4950 толгой бог, Ивэнгийн Чулуун хөндийн мал угаалгын ванн 45 өрхийн 24750 толгой бог мал, Бүрэнсүрэг мал эмнэлэг, үржлийн нэгж Шивээтийн мал угаалгын ваннд 36 өрхийн 18720 толгой бог мал, нийт 92 өрхийн 52920 толгой бог малыг угаалганд тус тус хамруулаад байна.

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 8 төрлийн вакцин ирснээс шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин 37,8 литр ирснийг 17905 толгой үхэр, 105 толгой гахайд 100 хувь тарьж дууссан, галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин 2 мянган тун ирснийг 2000 толгой үхэрт 100 хувь тарьж дууссан, боом өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин 3,4 литр ирснийг 6800 хонинд 100 хувь тарьж дууссан, боом өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин 17,4 литр ирснийг 17400 толгой үхэрт хийхээс 17400 толгой үхэрт буюу 100 хувь тарьж дууссан, дуут өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин 45 литр ирснийг 9000 толгой үхэрт хийхээс 9000 толгой үхэрт буюу 100 хувь тарьж дууссан, цусан халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин 50,4 литр ирснийг 3360 толгой үхэрт хийхээс 3360 толгой үхэрт буюу 100 хувь тарьж дууссан. Шөвөг яр өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин 25,8 литр тун ирснийг 25800 толгой хурга, ишгэнд хийхээс 18000 толгой хурга, ишиг буюу 32,3 хувьд, сахуу өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин 34,8 литр ирснийг 1740 толгой унаганд хийхээс 870 толгой унаганд буюу 50 хувьд, томуу өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин 18 литр ирснийг 3600 толгой адуунд хийхээс 1800 толгой адуу буюу 50 хувьд нь тус тус хийгээд байна.

Энэ онд 276 өрх 66347 тонн ноосыг Таван шар баялаг, Мөнх цаст хархираа, Магнай бүрэн зэрэг хоршоонд нийлүүлснээр холбогдох хоршооны эздүүдээс малчдын материалыг авч нэгтгэн аймгийн ХХААГ-т хүргүүлж урамшуулалд хамрагдах нөхцлийг бүрдүүлээд байна.

Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт хангалтгүй байгаа тул эргэн төлөлтийг сайжруулахын тулд хүү, алданги, зээлийг тооцон гаргаж хугацаа хэтрэлттэй зээлдэгч бүрт хүргүүлж ажилласан. Мөн энэ сард сум хөгжүүлэх сан бүртгэл, хяналт, нэгтгэлийн системийн программ суулгаж зээлдэгч нарын мэдээлэл программаар дамжигдаж аймагт хүргэгдэж Монгол банкинд очдог болохоор болоод байна. Одоогийн байдлаар үлдэгдэл 20800,0 мянган төгрөг байгаа нь 10 иргэн эргэн төлөлт хийснээс 4 иргэн зээлээ төлж дуусгаад байна.

Шаамар сум:

Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2018-2019 оны Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах тухай 2018 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 10 тоот албан даалгавар, сумын Засаг даргын 2018-2019 оны Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээ авах тухай 2018 оны 07 сарын 28-ны өдрийн А/97 тоот захирамжийн хүрээнд өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах нэгдсэн төлөвлөгөөг боловсруулан удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллаж байна.

Нийт нутгаар ойр ойрхон аадар бороо орж голын усны түвшин эрс нэмэгдэж эрэгээ халих, үер усны аюулт байдал үүсэх нөхцөл бүрдсэнтэй холбогдуулан Сумын Засаг даргын 2018 оны 07 сарын 24-ны өдрийн А/96 тоот захирамж Гол, усны үерээс урьдчилан сэргийлэх ажлын хэсэг байгуулж, хөдөлгөөнт эргүүл ажиллуулах захирамжийн хүрээнд хөдөлгөөнт эргүүлээр ажиллах нэгдсэн хуваарийг боловсруулан удирдлага зохион байгуулалтаар ханган, голын эрэг дагуу амьдарч буй 20 өрхөд урьдчилан сэргийлэх зорилгоор сэрэмжлүүлэг тараан ажилласан.

Малчин мал бүхий иргэдийн хадлан бэлтгэх ажлыг зохион байгуулж хуучин хадлангийн талбайтай иргэдийг газрын төлбөрийг тушаалгаж гэрээ байгуулахаар ажиллаж байна. Шинээр хадлангийн газар хүссэн 12 иргэний хүсэлтийг хүлээн авч ажилласан. Орон нутгийн өвсний нөөц бүрдүүлэх газрын судалгаа хийж сумын нөөц өвс бэлтгэх газрыг тэмээн хүзүүнээс 40 га газрыг сонгоод байна.

Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтэс, Дэлхийн Зөн Олон Улсын байгууллагын Сэлэнгэ орон нутгийн хөгжлийн хөтөлбөрөөс санаачлан зохион байгуулсан “Хүүхэд хамгаалалд хамтдаа” хамтарсан багийг чадавхжуулах сургалтанд сумын Засаг дарга, сумын нийгмийн ажилтан, хэсгийн төлөөлөгч, сумын Эрүүл мэндийн төвийн их эмч, багийн Засаг дарга нар хамрагдлаа. Мөн Дэлхийн Зөн Олон Улсын байгууллагын хойд бүсийн хөгжлийн хөтөлбөрөөс зохион байгуулсан “Монгол хүн хүүхдийн төлөө уулзалт, ярилцлага”-ийг зохион байгуулж сумын боловсролын байгууллагын нийт ажилтан албан хаагчид, иргэдийг хамрууллаа.

Нийгмийн даатгалын сангийн тайлан тэнцэлээр 2018 оны 8 сарын 24-ний байдлаар 24 ажил олгогч, 225 даатгуулагч нийгмийн даатгалын шимтгэл төлж, сайн дурын даатгалд шинээр 3 хүн хамруулж нийт 73 даатгуулагчийн шимтгэлийг сар болон улирлаар төлүүлж, сайн дурын даатгалд -288 иргэн гэрээтэй байна, хувиараа хөдөлмөр эрхлэгч -55, заавал даатгуулагчын 229 нийгмийн даатгалын дэвтэр, эрүүл мэндийн даатгалын дэвтрийг тухай бүр баталгаажуулж байна.

Баянгол сум:

Энэ хичээлийн жилд шинээр 1-р ангид элсэн орох хүүхдийг бүртгэлийг 8-р сарын 15-аас эхлүүлсэн бөгөөд нийт сумын хэмжээнд 120 гаруй хүүхэд хамрагдахаас 28-р сарын 25-ны байдлаар 62 хүүхэд бүртгүүлээд байна. Сурагчийн дүрэмт хувцсыг “Уран интерга” ХХК-тай хамтран сургууль дээр байршуулан худалдаалж байна.

Сумын эрүүл мэндийн төв тайлант хугацаанд амбулаториор нийт 461 иргэнийг үзлэгт хаамруулж, 16 иргэнийг онош тодруулахар дээд шатлалын эмнэлэгт илгээж, эх хүүхдийн эрүүл мэнд, хоол тэжээл хөтөлбөрийн хүрээнд 0-5 насны 114 хүүхдийг товллын дагуу дархлаажуулалтанд 100 хувь хамруулсан.

Үндэсний боловсруулах үйлдвэрт хонь, тэжээний ноос бэлтгэн тушаасан малчин, мал бүхий иргэдэд мөнгөн урамшуулах тухай Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 394-р тогтоолын дагуу 73 иргэний 26356 кг ноос тушаасан баримт материалыг бүрдүүлэн аймгийн ХХААГ-т хүргүүлсэн. МЭҮН-үүд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт вакцинуудыг хийж, боом өвчний тарилгад 14920 толгой бод, 7600 толгой бог, ДХХ тарилгад 3600 толгой бог, дуутын тарилгад 8300 толгой бод, цусан халдварын тарилгад 200 толгой бод, гахайн тарилгад 200 толгой гахай, сахуугийн тарилгад 1800 толгой мал, томуугийн тарилгад 300 толгой малыг хамруулаад байна.

Сумын хэмжээнд иргэд, аж ахуйн нэгжийн тариалсан ургацын урьдчилсан төлөвийг тогтоох ажлыг хэсгийг томилон ажиллуулж, талбай бүрээр орж ажилласан бөгөөд урьдчилсан байдлаар 1 га-гаас 13,5 цн ургац авах төлөвтэй байна.

Ойн тухай хуулийн дагуу түлээ бэлтгэх эрхийн бичгийг 6 иргэнд 40 куб мод бэлтгүүлэхээр, Түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах эрхийн бичгийг 5 иргэн, 1 аж ахуйн нэгжид голын хайрга 99 тн, элс 22 тн, дайрга 540 тн-ыг бэлтгэхээр олгож, нийт 916,1 мянган төгрөгийг төрийн санд төвлөрүүлсэн.

Сумын амьжиргааг дэмжих зөвлөл энэ сарын 11-ний өдөр хүнсний эрхийн бичгээр үйлчилгээ авдаг 33 өрхийн 33 иргэнтэй ганцаарчилсан уулзалт хийж, өрхөд тулгамдсан асуудлын талаар ярилцаж, “Дэлхийн зөн” ОУБ-ын Хөтөлбөр салбартай хамтран хүүхдийн хүмүүжил, хүүхэд хамгааллын чиглэлээр сургалт хийлээ. Мөн “Дэлхийн зөн Зүүнхараа” орон нутгийн хөтөлбөр гэрээр айлчлах хөтөлбөрт хамрагдаж буй 35 өрхөд 8-р сарын 13-14-ны өдрүүдэд “Гэр бүл, хувь хүний хөгжил”-ийн талаарх лекцийг явуулж, хууль сурталчлах арга хэмжээг зохион байгууллаа.

Сайхан сум:

Сумын ГХУССЗ-өөс “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн шилжин явах цом аялах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх хэсэгт “Байгууллагынхаа дотоодод болон үйл ажиллагаа явуулж байгаа хүрээндээ гэмт хэрэг гарч байгаа шалтгаан нөхцлийг арилгах талаар тодорхой арга хэмжээ авах” гэж заасны дагуу сумын ЗДТГ-т энэ сарын 6-аас 13-ны өдрүүдэд “Шилжин явах цом”-ыг аялуулсан. Мөн

сумын хэмжээнд гарч буй нийт гэмт хэрэг, зөрчлийн байдлыг харгалзан үзээд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 27.10 дугаар зүйлд заасан “Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих” гэмт хэргийн үйлдэгдэн гарч байгаа шалтгаан нөхцлийг арилгах талаарх ажлыг 2018 оны 08 дугаар сарын 09-ний өдөр зохион байгууллаа. Орон нутагт осол, хэргийн улмаас нас барсан, гэмтсэн хүний тоо өсөлттэй байгаа нь согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох, бүрэн бус тээврийн хэрэгсэлтэй хөдөлгөөнд оролцох, замын нөхцөлд хурд тохируулахгүй, гүйцэж түрүүлэх үйлдлийг буруу хийх, хамгаалах бүс, малгай, хүүхдийн суудал хэрэглээгүй зэрэг шалтгаантай байгааг харгалзан замын хөдөлгөөнд оролцогчдод Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай, Зөрчлийн тухай хуулиудыг сурталчлах, таниулах зорилгоор замын хөдөлгөөнд анхаарал болгоомжтой, соёлтой оролцох, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх тухай 50 ширхэг гарын авлага, материалыг тээврийн хэрэгслийн жолооч нарт тараалаа.

Сумын Засаг даргын албан тоотоор сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж, байгууллага болон жижиг дунд үйлдвэрлэл, бизнес эрхлэгчдэд хугацаатай албан тоотыг хүргүүлж, 08 дугаар сарын 04-ний өдөр нийтийн эзэмшлийн зам талбайд ургасан шарилж, хог ургамлыг цэвэрлэллээ. Энэхүү ажлын хүрээнд нийт 4 орчим га талбайн хог ургамлыг устгасан.

Тус сумын малчдаас 2018 онд ноосны урамшуулалд хамрагдах нийт 43 иргэний 47 ноосны урамшуулалд хамрагдах материалыг ARIS- программд шивж оруулан, аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүлсэн.

Мал аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зорилгоор сумын Засаг даргын захирамжаар хадлангийн талбайг ашиглах, зохицуулах ажлын зохион байгуулах ажлын хэсэг томилогдон малчин, мал бүхий иргэдээс нийт 286 өргөдлийг хүлээн авч, хадлангийн талбайг малын А данстай, орон нутгин мал бүхий иргэдэд олгох чиглэлийг баримтлан олголоо.

Мал, амьтны халдварт өвчний талаархи тайлан мэдээг аймгийн Мал эмнэлгийн албанд файлаар хүргүүлсэн. Мөн Номгон 3-р баг “Цөм сүрэг” МЭҮН-ийн тарилгын материалыг хүргүүлж санхүүжилтийг олгосон.

Болзошгүй үер усны аюулаас урьдчилан сэргийлэх Засаг даргын А/192 дугаартай захирамжийн хэрэгжилтийг хангуулахаар Сум дундын Цагдаагийн хэлтэс, Аврах, гал түймэр унтраах 61-р ангитай хамтран Хараа, Орхон голын сав дагуу хяналт шалгалтын ажлыг хийж, нийт 30 иргэнд үер усны талаарх гарын авлага тараах материал бэлтгэн танилцуулж, анхааруулах самбар байрлуулсан.

Цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээгээр 2018 оны 7, 8 дугаар сард түр зуурын усархаг аадар бороо, мөндөр, үер, аянга буух, голын усны түвшин огцом нэмэгдэх, хүчтэй салхи шуурга болох зэрэг цаг агаарын аюулт болон гамшигт үзэгдлийн тоо, давтамж нэмэгдэх хандлагатай гэсэн сэрэмжлүүлэг, урьдчилан сэргийлэх албан тоотын хүрээнд орон нутгийн зүгээс үер, усны аюулаас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх ажлыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, далан сувгийн хяналт шалгалтыг Аврах, гал түймэр унтраах 61 дүгээр ангийн албан хаагчидтай хамтран зохион байгууллаа. уучин гольдрол өөрчлөгдсөн далан сувгийг үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагуудын тусламжтайгаар сэргээн засварлах, шинээр бий болгох ажлыг хийсэн.

Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр 3 бичил хорооллын дунд тус бүр иж бүрэн тоглоом суурилуулсан. Мөн үерийн далан дээгүүр явган хүний зам шинээр тавьж, амын сангийн хөрөнгөөр хийгдэх “Зам засвар, тэмдэг тэмдэглэгээ хийх ажил”-д “Хомын Тал” ХХК нь шалгарч, Номгон тосгонд хурд сааруулагч 2 ширхэг, тэмдэглэгээ 8 ширхэг хийгдсэн. Мөн Хөтөл хотын төв замын нөхөөс хийгдэж гүйцэтгэл 80 гаруй хувьтай, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжигдэх “Номгон тосгоны хогийн цэгийг хашаажуулах ажил”-ын тендерт “Сайхан Төгөл” ХХК шалгарч ажлыг эхлүүлсэн бөгөөд гүйцэтгэл 30 гаруй хувьтай явагдаж байна.

УИХ-ын гишүүн Д.Эрдэнэбатын нэрэмжит “Малчдын бэсрэг наадам-2018” арга хэмжээг 2018 оны 08 дугаар сарын 04-ний өдөр Номгон 3-р баг, Дэрст буланд зохион

байгуулав. Уг арга хэмжээний хүрээнд даага, шүдлэн насны морины уралдаан, хүчит 32 бөхийн барилдаан, шатар даамны тэмцээн /хүүхдийн даам, насанд хүрэгчдийн шатар, даам/, холимог багийн волейболын тэмцээн /эрэгтэй 4, эмэгтэй 2/ гэх мэт тэмцээн уралдааныг амжилттай зохион байгуулж, нийт 300 гаруй малчдыг хамрууллаа.

Гэр бүл рүү чиглэсэн арга хэмжээг идэвхтэй явуулж, аав хүний эрхэм чанар, үнэлэмжийг дээшлүүлэхэд анхаарч, бодлогоор дэмжих, иргэдийг хууль эрх зүй, ёс суртахууны мэдлэгтэй болгоход анхаарах, хүүхэд хамгааллын чиглэлээр явуулж буй бүхий л үйл ажиллагаанд аавуудыг хамтад нь идэвхтэй оролцуулах, аавуудын гэр бүлийн боловсролыг нэмэгдүүлэх, гэр бүлийн харилцааны эерэг хандлагыг бий болгох, мөн сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.5.9. дахь заалт, Гэр бүлийн хөгжлийг дэмжих “Жаргалтай гэр бүл” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор 2018 оны 08 дугаар сарын 07, 08-ны өдрүүдэд “Аавуудын баяр”-ыг ДЗОУБ-тай хамтран зохион байгууллаа. Арга хэмжээний хүрээнд “Хариуцлагатай аав-жаргалтай гэр бүл” сэдвээр хэлэлцүүлэг, аавуудын дунд нөхөрсөг, хөгжөөнт тэмцээнийг явуулж, сумын “Аавуудын холбоо”-г байгуулж холбооны тэргүүнийг сонголоо.

Энэ хичээлийн жилд цэцэрлэгт 646 хүүхэд хамрагдаж байгаа бол 1 дүгээр ангид элсэгчдийн тоо урьдчилсан байдлаар 149 байна.

Ерөө сум:

Сэлэнгэ аймагт болсон “Соёлын биет бус өв”-ийн их наадамд ардын авьяастан Гомпил уртын дуугаар алтан медаль хүртэж, Буриад дуугаар Булганчимэг мөнгөн медаль хүртэлж, Улаанбаатар хотод болсон “Нүүдэлчин Монгол 2018” арга хэмжээнд аймгаа төлөөлөн оролцлоо.

2018 оны 08-р сарын 10-ны өдөр Ерөө сумын 2-р багийн малчдын өдөрлөгийг зохион байгуулж, эм, эмнэлэгийн үйлчилгээ үзүүлж, урлагийн тоглолтоор мэндчилгээ хүргэн малчдын дунд Үндэсний бөхийн барилдаан, морь бугуйлдах, ташуур шүүрэх тэмцээн, хөгжилтэй буухиа, караоке дууны тэмцээн, үдэшлэг цэнгүүнийг тус тус явуулж, Ойн хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх тухай”, “Хог хаягдлыгн тухай”, “Хууль бус мод бэлтгэл”-ийн талаар гарын авлага тарааж тайлбарлан таниулах арга хэмжээ авлаа.

Ерөө сумын төв болон Бугант тосгоны төвд явган хүний зам тавих ажлыг “Энх шилтгээн” ХХК-аар хийж гүйцэтгүүлж байна. Уг ажилд 30 сая төгрөг төсөвлөсөн ба одоогийн байдлаар ажил 80 хувьтай явагдаж байна.

Иргэний улсын бүртгэл хөтлөх журмыг үндэслэн сумын хэмжээнд шинээр төрсөн 11, эцэг тогтоолгосон 4, шинээр гэр бүл болсон 2, нас барсан 3 иргэний хүсэлт материалыг хүлээн авч бүртгэн гэрчилгээ олгож, шилжин суурьших хүсэлтээ гаргасан иргэдийн бүрдүүлсэн нотлох баримтыг үндэслэн шилжин ирсэн 9, шилжин явсан 13 иргэний бүртгэн мэдээллийн санд оруулж, иргэний үнэмлэх шинээр авах 10, хүчинтэй хугацааг сунгуулах 12, хаяж гээсэн, хүчинтэй байдлыг алдагдуулсан 15 иргэний хүсэлтийг хүлээн авч бүртгэн ИУБ маягтуудыг, квитанцын хамт УБХ-т хүргүүлж, хэвлэгдэн гарсан нийт 13 иргэний цахим үнэмлэхийг ИУБ-21 маягт хөтлөн баталгаажуулан эздэд нь олгоод байна. Мөн Эд хөрөнгөө эрхийн бүртгэлд бүртгүүлэхийн ач тус, эрхийн бүртгэлтэй холбоотой хууль эрхзүйн талаар болон улсын бүртгэлд бүртгүүлэхэд бүрдүүлэх материалын жагсаалт зэргээр иргэдэд зөвлөгөө өгч төрөөс үнэ төлбөргүй өмчилсөн газраа улсын бүртгэлд анх удаа бүртгүүлэхээр хүсэлт гаргасан 2, өөрт ногдох хэсгийг бусдад бэлэглэх гэрээний 1, ҮХЭХ-ийн лавлагаа 1, барьцаалбарын гэрээг дуусгавар болгох 2 иргэн хүсэлт гаргасны нотлох баримтууд, мэдүүлгийг хүлээн авч хянан ЭХЭБ-ийн тасагт хүргүүлж хэвлэгдэн гарсан үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн 3, газар өмчлөлийн 16 гэрчилгээг бүртгэл хөтлөн эздэд нь олголоо.

Зүүнбүрэн сум:

Боловсрол, соёл шинжлэх ухааны сайдын 2018 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн 1а/9607 тоот албан бичгээр өгөгдсөн үүргийн дагуу 2018-2019 оны хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажил болон өвөлжилтийн бэлтгэлийг хангах тухай болон аймгийн Мэргэжлийн хяналтын газраас ирүүлсэн албан тоотоор өгөгдсөн үүрэг чиглэлийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Иргэний гэр бүлийн тухай хуулийн хүрээнд шинэ төрсөн 2, овог нэр өөрчлөлт 1, иргэний үнэмлэх олголт 16, иргэний үнэмлэх хаяж гээсэн 2 иргэнийг дахин үнэмлэхжүүллээ. Биеийн давхацахгүй өгөгдлийн бүртгэл 7, шилжин ирсэн 5, шилжин явсан 7 нийт 40 иргэнд бүртгэлийн үйлчилгээ үзүүллээ.

Эрүүл мэндийн төвөөс тайлант сард амбулаториор 235 иргэнд үзлэг хийж, 25 иргэнийг хэвтүүлэн эмчиллээ. Ээлжит товлотт вакцинд 1 хүртэлх насны хүүхдийг 100 хувь хамрууллаа.

Мал амьтныг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилганд 45620 толгой, угаалга, туулгалтанд 11757 толгой малыг тус тус хамрууллаа.

Сумын наадмын талбайн саравч, урлагийн тайз барих ажлыг аймгийн хөрөнгө оруулалтаар “Чонос девелопмент” ХХК гүйцэтгэж, хүлээлгэн өгсөн. Мөн орон нутгийн хөгжлийн сангийн 65.0 сая төгрөгийн хөрөнгөөр “Сэлэнгэ баян уул” ХХК нь сумын Засаг даргын Тамгын газарт универсаль трактор нийлүүллээ.

Мандал сум:

Мандал сум дахь хууль хяналтын байгууллагуудын "Нээлттэй хаалганы өдөрлөг"-ийг худалдааны гудамжинд зохион байгуулж, Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Зөрчлийн тухай, Гэр бүлийн хүчирхийллийн тухай, Галт зэвсгийн тухай хуулиар мэдээлэл өгч, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, Шүүхээр хэрэг хянан шийдвэрлүүлэх үйл ажиллагааны талаар иргэдэд мэдээлэл өгч, гарын авлага, санамж, сэрэмжлүүлэгийг тараасан. Мөн сум дундын Цагдаагийн хэлтэс, Хүүхдийн ордон хамтран хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг 108 өрхийн 120 гишүүнд хууль, харилцааны талаар мэдлэг олгох сургалтыг зохион байгуулж, нийгмийн халамжийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл, ХЭБ-ийн үйлчилгээ олгох журам, гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэргийн нөхцөл байдлын мэдээлэл, гэр бүлийн эерэг харилцаа, харилцааны ур чадварын талаар мэдлэг олголоо.

Сумын амьжиргаа дэмжих зөвлөлийн хурлыг 1 удаа зохион байгуулж 17 иргэний асуудлыг шийдвэрлэж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн салбар зөвлөлтэй хамтран тэдний хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүний борлуулалтыг сайжруулах, олон нийтэд сурталчлах зорилгоор 08-р сарын 18-10-р сарын 10-ны өдрийг хүртэл “Намрын ногоон өдрүүд” үзэсгэлэн худалдааг зохион байгуулж эхлээд байна. Мөн зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах зорилгоор “Өрхийн хөгжлөөс-Сумын хөгжил” сайн үйлсийн аяныг явуулж, 7-р багийн иргэн Б.Сүхбатын гэр бүлд 5*7 харьцаатай байшинг барьж дуусгалаа.

7, 8 дугаар саруудад үргэлжлэн орсон ширүүн борооны улмаас үүссэн нөхцөл байдал, эвдэрсэн үерийн далан, шуудуу, засмал замыг цэвэрлэх, сэргээн засварлах шуурхай арга хэмжээг авч ажилаллаа.

Сумын төв доторх 1.6 км хатуу хучилттай асфальтан замыг ашиглалтанд оруулж, төмөр замын гармаас 1-р сургуулийн төмөр гүүр хүртэл, вокзалын хойд талаас хуучнаар ахмадын сувилал хүртэл, спортын ордны уулзвараас “Цант Орхон” ХХК-ний уулзвар хүртэлх 3 хэсэг газарт 2,58 км зам барилгын ажлыг эхлүүлж, гүйцэтгэл 80 гаруй хувьтай үргэлжилж байна. “Сэлэнгэ Зүүнхараа” ОНӨААТҮГ нь өөрийн техник тоног төхөөрөмжөөр Хужиртын уулзвараас Зуун модны ам хүртэлх сайжруулсан замыг хусаж засварлалаа.

Мөн сумын төв доторх болон Хужиртын бригадаас Дархан-Сэлэнгийн төв зам хүртэлх хайрган замуудыг хусаж сайжруулах ажлыг эхлүүлж, сумын замын тэмдэг тэмдэглэгээний ажлыг хийж гүйцэтгэх байгууллагыг сонгон шалгаруулах ажлыг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем tender.gov.mn сайтад тендерийн урилгыг байршуулж, цахим хэлбэрээр худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна.

Сумын төвийн ЕБС-иудын хичээлийн шинэ жилийн бэлтгэл, өвөлжилтийн бэлтгэл ажилтай сумын Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсэг шалган танилцаж, хүүхдийн эрүүл аюулгүй орчин нөхцөлд сурч боловсроход анхаар чажиллахыг даалгалаа.

Үндэсний үйлдвэрт хонины ноос тушаан урамшуулалд хамрагдахаар материал бүрдүүлсэн 40 иргэний материалыг аймгийн хүнс хөдөө аж ахуйн газарт хүргүүлж, Хадлангийн талбай ашиглах хүсэлт гаргасан 80 иргэнтэй хадлангийн талбай ашиглуулах гэрээ байгуулаад байна.

Хортон шавьжийн тэмцлийн ажлыг Сэлэнгэ аймгийн төсвөөр Гранд форест ХХК Мандал сумын Тарни, Хараа голын эрэг дагуу нийт 770 га талбайд хайлаасны цох гэх шавьжинд химийн аргаар тэмцлийн ажил явуулсан.

Мөн Улсын төсвийн хөрөнгөөр "Ойн таксац" ХХК, "Залуу төгөл" ХХК нь Ар гахайт, Өвөр гахайт, Тарни, Хургалаг, Үнэглэг, Түнхэл Буянт, Тусгалт, 84-р Зөрлөг гэх газруудад нийт 5000 га талбайд гэрлэн урхиар 388270 ш өрөөсгөл хүр эрвээхэй, устгасан байна.

Орхон сум:

2018 оны 08-р сарын 06-ны өдөр Орхон сумын Бэлэндалай баг "Орхон далай" ХХК дээр ОХУ-аас нийлүүлэгдэж буй техник тоног төхөөрөмжийг хүлээн авах арга хэмжээг зохион байгууллаа. Тус арга хэмжээнд Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд н.Батзориг, ОХУ-аас Монгол Улсад суугаа төлөөлөгчийн газрын дарга, тариалан эрхлэлтийг дэмжих сангийн төлөөлөгчид, үр тарианы аж ахуйн нэгж, иргэд оролцож техник худалдан авсан аж ахуйн нэгжүүдэд түлхүүрийг гардуулан өглөө. Мөн шинээр нийлүүлэгдэж байгаа техникийн үзүүлэх сургалт зохион байгуулагдлаа.

Энэ сарын 15-17-ны өдрүүдэд хадлангийн газрын гэрээ байгуулах зар мэдээллийг малчин, мал бүхий иргэдэд хүргэсэн. Орхон багаас нийт 127 малчин мал бүхий иргэдээс 104 иргэн гэрээ байгуулсан.

Ургац тогтоолтын урьдчилсан балансыг Баюудай, Мангирт, Мэргэн шувуут, Шар хөтөл, Гүн гуу, Бэлэндалай, Өнгөтийн ар, Шийр, Худгийн хоолойн чиглэлд нийт 35 аж ахуйн нэгж, 100 иргэний нийт 12330 га талбайд хийлээ. Сумын нийт үр тарианы 400 га талбай малын тэжээлд шилжиж хураах боломжгүй болсон байна.

Сумын хэмжээнд энэ онд 7986 га талбайгаас 9051 тн ургац, га-ийн ургац 11,3 цн, төмс 300 га талбайгаас 4552 тн, га-ийн ургац 150,1 цн, хүнсний ногоо 166 га талбайгаас 1884 тн, га-ийн ургац 110,3 цн-ээр тус тус тогтоогоод байна.

2018 оны 08-р сарын 03-ны өдөр Орхон сумын Бэлэндалай багийн өдөрлөг Нилчингийн хөндийд зохион байгуулагдаж өндөрлөлөө. Өдөрлөгийн хүрээнд цолгүй бөхчүүдийн барилдааныг зохион байгуулж 64 бөх зодоглож Сайхан сумын залуу бөх Б.Ган-Оргил түрүүлж, Орхонтуул сумын залуу бөх Б.Уртнасан үзүүрлэлээ. Мөн 7 дахь жилдээ уламжлал болгон адуучин тэмцээнийг зохион байгуулж тэмцээнд 45 адуучин залуус оролцлоо.

2018 оны 08-р сарын 05-ны өдөр УИХ-ын гишүүн Д.Эрдэнэбатын нэрэмжит малчдын бэсрэг наадам Орхон сумын Дэрст буланд зохион байгуулагдаж малчин, мал бүхий иргэд амжилттай оролцлоо.

Сант сум:

Өвөлжилтийн бэлтгэл хангуулах зарим арга хэмжээний тухай сумын Засаг даргын 2018 оны А/62 тоот захирамжийн дагуу ажлын хэсэг байгуулагдан хадлан

тэжээлийн бэлтгэл, орон нутгийн өвсний нөөц бүрдүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Сумын ойн санд хүрэнцэрийн устгалын ажлыг “Хатант Порест” ХХК 10 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэн 4950 га талбай хамрагдсан. Мөн сумын ойн сангийн Орхон голын бургас, Хойд булаг, Тэлд, Хушаатын шинэсэн ойн санд эрвээхэйн судалгааг хийлээ.

Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фотомониторингийн аргаар үнэлэх ажлын хэсэг байгуулагдан сумын хэмжээнд геодизийн 5 цэгт дахин фотомониторинг, нэмж 3 цэгт шинээр фотомониторинг хийж, аймгийн Бэлчээр ашиглалтын холбоо ТББ-аас “Ногоон алт- Малын эрүүл мэнд” төслийн хүрээнд бэлчээр ашиглалтын менежментийг сайжруулах талаар сургалт зохион байгуулагдаж малчдын 9 бүлгийн төлөөлөл, сумын удирдлага, холбогдох мэргэжилтнүүд хамрагдсан.

Улсын төсвийн хөрөнгө оруулалт 158,5 сая төгрөгийн санхүүжилтээр сумын 13-р хүүхдийн цэцэрлэгийн барилгын их засварын ажил 2018 оны 08 дугаар сарын 06-ны өдрөөс эхэлсэн ба ажлын гүйцэтгэл 50 гаруй хувьтай явагдаж байна. СӨБ-ын хувилбарт сургалт буюу зуны гэр цэцэрлэг Ивэн 1-р багийн Тэлдийн зусланд нэг бүлгээр ажилласан ба 25 хүүхэд хамрагдаж хамран сургалтын хувийг нэмэгдүүлсэн байна.

“Дэлхийн зөн Монгол” олон улсын байгууллагаас Сэлэнгэ нутгийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд хүүхэд хөгжил, хүүхэд хамгаалал, өрхийн амьжиргааг дэмжих чиглэлээр “Хүүхэд ивээн тэтгэх хөтөлбөр”-т орон нутгийн төлөөлөл болсон 4-11 насны хүүхдүүдийг бүртгэх ажил зохион байгуулагдаж сумаас 65 хүүхэд хамрагдсан байна.

Сумын Соёлын төвөөс хөдөөгийн иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, мэдээллээр хангах зорилгоор 1-р багийн Тэлдийн зусланд “Нүүдлийн номын сан”-г 16 хоногийн хугацаатайгаар ажиллуулж давхардсан тоогоор 182 иргэнд 240 ширхэг ном, сонин сэтгүүлээр үйлчилсэн байна. Зөөврийн үйлчилгээгээр 24 өрхөд 32 ширхэг номоор үйлчилж ажилласан байна.

Орхонтуул сүм:

Тайлант сард сумын Засаг даргын Тамгын газраас иргэдэд хүргэх төрийн үйлчилгээг хурдан шуурхай байдлыг хангаж ажиллалаа. Төрийн үйлчилгээ авах иргэдийн цаг хугацааг хэмнэх шуурхай байдлыг сайжруулах зорилгоор байгууллагын нөөц бололцоонд тулгуурлан өрөөний зохион байгуулалтанд өөрчлөлт оруулах ажлыг энэ сард хийж гүйцэтгэлээ.

2018-2019 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын төлөвлөгөө гарган ажлын хэсэг байгуулан иргэдэд ахуйн болон бизнесийн хадлангийн газар эзэмшүүлэх ажил хийгдсэн. Ургацын мэдээгээр сумын хэмжээнд дунджаар 1 га-аас 10 цн ургац хураан авах төлөвтэй байна. Малын гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх тандалт хийх ажлаар хөдөөгүүр ажиллаж өвчний голомттой бүсээс олон тооны мал тууварлан ирж байгаа гэсэн мэдээллийн дагуу Баянцогт 2-р багийн иргэн Б.Батбаатар, Д.Эрдэнэбат, Б.Цэрэнбалтав, П.Санж нарын малчдад мэдэгдэл өгч хяналт тавин ажиллаж байна.

Ойн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор хяналт шалгалтуудыг ой бүхий газруудад хийж, ой хаасан хугацаанд ойн дагалдах баялаг ашиглахгүй байх ой хээрт аялал зугаалга хийхгүй байх талаар анхааруулга санамж бичиг тарааж ухуулга сурталчилгаа хийж ажиллалаа. Газрын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор тус сумын Шар-Ус 1-р баг Рашаант тосгоны нутаг Цуу тайж, Бургалтайн гол мөн Хонгор-Овоо 3-р багийн нутаг Бичигтийн эрүү гэх газраар зусаж намаржиж буй малчин иргэдийн дунд гарсан бэлчээр ашиглалт, өвөлжөө, хадлангийн талбайн маргааныг шийдвэрлэж гарсан зөрчлийг таслан зогсоох хяналт шалгалтын ажил зохион байгуулж Байгаль орчны багц хууль болох Хог хаягдлын хууль, Ойн тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай, Зөрчлийн хуулиудаар хуулийн сургалт сурталчилгаа хийсэн байна.

Энэ хичээлийн жилд шинээр 1-р ангид элсэн орох 2012 онд төрсөн хүүхдүүдийг 8-р сарын 3-аас эхлэн бүртгэсэн бөгөөд одоогийн байдлаар нийт бүртгүүлэх хүүхдүүдийн 60 гаруй хувь нь бүртгүүлсэн. Суралцагчдын дүрэмт хувцсыг албан ёсны ханган нийлүүлэгч “Уран энтегра” ХХК-ний борлуулсан.

“Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийн хүрээнд 8-р сарын эхний 7 хоногийг эхийн сүүгээр хооллолтыг дэмжих “ЭХИЙН СҮҮ-ЭРҮҮЛ АМЬДРАЛЫН ЭХЛЭЛ” сэдэв уриан дор төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж, 0-2 насны хүүхдээ асарч буй эхчүүд болон жирэмсний хяналтад байдаг эхчүүдэд урилга өгч 2 баг дээр тус тусад нь өдөрлөг зохион байгуулж сургалт хийсэн ба ээжүүдийн дунд тэмцээн уралдаан зохион явуулж 70 гаруй хүн хамрагдлаа. Өдөрлөгийн үеэр 41 хүний артерийн даралтыг үзэж, биеийн жингийн индексийг тодорхойлж эрүүл мэндийн зөвөлгөө өглөө.

Тус сард ажил хайгч иргэнээр 9 иргэн бүртгүүлсэн ба зуучлалаар 6 иргэн ажилд зуучлагдсан байна. Үүнд: Эрүүл мэндийн төвд их эмч-1, Хүдэр хүслэн ХХК-2, ЗДТГазарт -1, Дархан төмөрлөгийн үйлдвэрт- 2 иргэн нийт 6 ажил хайгч иргэн ажлын байранд зуучлагдсан. Аймгийн Засаг даргын 2018 оны 08 дугаар сарын 09-ны өдрийн “Хамтарсан багийн гишүүдийг чадавхижуулах, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг сайжруулах” сэдэвт сургалтанд сумын хамтарсан баг хамрагдаж, 2018 оны 08 сард хүнсний эрхийн бичгээр үйлчилгээнд хамрагдаж буй 24 өрхөд хүсний эрхийн бичиг олгосон.

Тайлант сард төрсний бүртгэлд 8 хүүхэд бүртгүүлж РД олгосноос эрэгтэй 5, эмэгтэй 3 хүүхэд гэрчилгээ авсан. Мөн нөхөн эцэг тогтоолтын бүртгэл 5 хүүхэд хийгдсэн. 16 нас хүрсэн 7 иргэн, 25, 45 насны сунгалт хийлгэсэн 12 иргэн байна. Үүнээс гадна цахим үнэмлэхээ гээгдүүлсэн 2 иргэн үнэмлэхээ захиалж, хэвлэгдэн ирсэн 12 иргэний цахим үнэмлэхийг олгосон байна. Өөр аймаг, сумаас шилжин ирсэн 5, баг хоорондын шилжүүлэг хийлгэсэн 1, шилжиж явсан 5 иргэн байна. 12 иргэний үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ авахаар бүрдүүлсэн материалыг хүлээн авч аймагт хүргэж өгсөн. Хэвлэгдэн ирсэн 10 иргэний газрын гэрчилгээг олголоо. Тайлант сард мэргэжил арга зүйн зөвөлгөө мэдээллийг давхардсан тоогоор 20 гаруй иргэдэд хүргэсэн байна.

Жавхлант сум:

Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангахаар сумын Засаг даргын А/106 дугаар захирамж, 10 дугаар албан даалгавар, нэгдсэн төлөвлөгөө гарч албан байгууллага, аж ахуйн нэгж, багийн Засаг дарга нарт хүргүүлж биелэлтийг тооцон ажиллаж байна.

Сумын хэмжээнд 2018 онд нийт 9543 га талбайд 15 аж ахуйн нэгж, 7 иргэн улаан буудай, тосны ургамал, 2 аж ахуйн нэгж, 67 иргэн 53 га-д төмс, 116 га-д хүнсний ногоо тариалсан. Үүнээс: 8287 га-д улаан буудай, 1240 га-д рапс, 16 га талбайд тэжээлийн ургамал тариалснаас нэгж га улаан буудайн дундаж ургац 12,5 цн, нэгж га тосны ургамлын дундаж ургац 4,9 цн, төмсний дундаж ургац 132 цн, хүнсний ногооны дундаж ургац 156 цн-ээр тогтсон урьдчилсан ургацын дүн гарснаар манай сум намрын ургац хураалтаар 10358,7 тн улаанбуудай, 620 тн рапс, 700 тн төмс, 1810 тн хүнсний ногоо хураах боломжтой байгаа бөгөөд цаг агаарын нөхцөл байдал, техникийн засвар үйлчилгээ, хүн хүчний нөөцөөс ихээхэн шалтгаалах болоод байна.

Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд малчид, иргэд хадлан бэлтгэх ажлын хүрээнд хадлан бэлтгэх иргэд сумын Газрын даамалд хадлан бэлтгэх талбайн тойм зураг, газар ашиглах өргөдөл зэргийг бүрдүүлэн авч гэрээ байгуулж байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газар, Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, Дэлхийн зөн Монгол ОУБайгууллагын Сэлэнгэ нутгийн хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр зохион байгуулсан “Хүүхэд хамгаалалд хамтдаа” сэдэвт сумдын хамтарсан багийн гишүүдийг чадавхижуулах сургалтанд тус сумын хамтарсан багийн гишүүд хамрагдлаа. Уг сургалт нь хүүхдийг нийгмийн бүхий л хүрээнд бүх хэлбэрийн хүчирхийллээс ангид байлгахад орон нутагт хүүхэд хамгааллын тогтолцоог

бэхжүүлэх, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн өрхүүдтэй хамтарсан баг хэрхэн ажиллах, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг хэрхэн үзүүлэх талаар хамтарсан багийн гишүүдийн арга зүйг нэмэгдүүлэх зорилготойгоор зохион буайгуулж, Моностой 2 иргэнд гэр олголоо. Мөн 1 дүгээр багийн өдөрлөгөөр алтан төлийн эзэн Ц.Бат-Эрдэнэ нь зорилтод бүлгийн өрх Б.Болдбаатарт 10 хурга өгч амьдралд нь дэмжлэг тусламж үзүүллээ.

Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг “Бид он цагийн хэлхээс” зүүн бүсийн залуучуудын баярыг амжилттай зохион байгуулагдлаа.

Нийгмийн даатгалын сангаас өндөр настны тэтгэвэрт 222 иргэнд 66377,3 мянган төгрөг, тахир дутуугийн тэтгэвэрт 60 иргэнд нийт 15386,7 мянган төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэвэрт 15-н иргэнд 3904,0 мянган төгрөг ЦӨН 3-н иргэнд 1523,2 мянган төгрөг оршуулгын тэтгэмж 2 иргэд 2000,0 төгрөгийг тус тус олголлоо.

Сургууль, Цэцэрлэгийн хүүхдүүдэд шээс, цагаан хорхой илрүүлэх шинжилгээнд 18 хамруулсанаас өндөг илэрсэн 1 хүүхдийг эмийн эмчилгээнд хамруулаад байна.Артерийн даралт илрүүлэх давтан үзлэгт 40-64 насны 42 иргэнийг, чихрийн шижин илрүүлэх үзлэг шинжилгээнд анх удаа 8 хүнийг хамруулсан.

“Элэг бүтэн Монгол “ хөтөлбөрийн хүрээнд 15-39 насны иргэдэд элэгний В,С вирусны илрүүлэх үзлэг шинжилгээнд 10 хүнийг хамруулж С вирус эерэг-0, В вирус эерэг -1 хүнийг дээд шатны эмнэлэгт онош баталгаажуулахаар илгээсэн.

Ерөнхий боловсролын сургууль нь 2018-2019 оны хичээлийн жилийн бэлтгэл ажлын хүрээнд багш нар 7 хоногийн хугацаатай сурагчдад мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтанд хамрагдаж, сургуулийн дотуур байр болон сургуулийн их засварын ажил 90 хувьтай явагдаж байна. “Уран интегра” ХХК дүрэмт хувцасыг захиалж сурагчдыг дүрэмт хувцасаар хангаж байна.

Монголын Соёлын ажилтаны баярыг угтан байгууллагын ажилчдын дунд “Бүтээлч баг” 14 хоногийн аянг зарлаад байна. Соёлын төв, Бумбат, Моностой багуудын өдөрлөгийг ЗДТГ, Багийн Засаг даргатай нартай хамтран зохион байгууллаа.

Өдөрлөгийн үеэр “Соёл урлаг хүний хөгжилд” 2-р аяны хүрээнд ахмад ардын авьяастануудын “Ахмадууд дуулж байна”урлагийн тоглолтыг иргэдэдээ толилуулж мөн наадамчин олны дунд үндэсний бөхийн барилдаан,хурдан морины уралдаан, гар бөмбөгийн тэмцээн, хөгжилтэй буухиа, караоке дууны тэмцээн, үдшийн цэнгүүнийг явууллаа. Мөн 21 аймгийн хоршоологчдын төлөөлөл оролцсон уулзалт өдөрлөг "Цагаан эсгийний баяр"-ыг ИТХурал, ЗДТГазар,Таван богд хоршоо, Ахмадын хороо болон малчдын бүлэг, соёлын биет бус өв тээгч иргэдтэй хамтран өргөн дэлгэр зохион байгуулан “Монгол өв соёл” шинэ уран бүтээл, монгол зан үйл эсгий хийх үйлийг сум орон нутгийн иргэд, гадны зочид төлөөллөгчид сурталчлан, соёл урлагийн үйлчилгээ үзүүллээ.

Улс, аймгийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалтын ажлууд амжилттай хийгдэж байна. Үүнд:

-Аймгийн 55,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Төрийн албан хаагчдын орон сууц барих”ажлын гүйцэтгэл 100 хувьтай, Сумын ОНХСангийн хөрөнгөөр хийхээр төлөвлөгдсөн Буйлаастанд худаг гаргах ажлыг “Бодь хараа” ХХКомпани хийж гүйцэтгэсэн.

-Замын сангийн 20,0 сая төгрөгийн Зам засах цамхагт гэрэлтүүлэг барих ажлыг “Сэлэнгэ Есөн эрдэнэ” ХХКомпани гүйцэтгэж, 50 хувийн гүйцэтгэлтэй.

-Нэгдсэн халаалтын зуух барих ажлыг “ММСтрейденг” ХХКомпани концессын гэрээгээр барихаар, Хүйтний голын багийн эмчийн байр барих ажлыг иргэдийн Нөхөрлөл бүлэг барихаар гэрээ байгуулан тус тус ажлаа эхлүүлсэн.

Сүхбаатар сум:

Тус сумын хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, ажлыг эрчимжүүлэх, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд нутгийн удирдлагын байгууллага, төрийн захиргаа, аж ахуйн нэгж, байгууллагуудын идэвх оролцоог нэмэгдүүлэх, иргэд

олон нийтийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, гэмт хэрэг зөрчлийн хэмжээг бууруулах зорилгоор Сүхбаатар сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Сэлэнгэ аймаг дахь Цагдаагийн газар хамтран Сүхбаатар сумын 8 багуудын дунд "Гэмт хэрэг зөрчилгүй баг, хамт олон" аян, болзолт уралдааныг 2018 оны 07 дугаар сарын 26-наас 11 дүгээр сарын 26-ныг хүртэл хугацаанд зохион байгуулан ажиллаж байна. Уг аяны хүрээнд Хонгорморьт 1-р багт гэмт хэрэг, зөрчлийн тухай хуулиар 6 удаагийн сургалт хийж нийт 210 иргэнийг хамрууллаа.

УИХ-н гишүүн Н.Оюундарийн нэрэмжит "Иргэдийн спортын анхдугаар наадам"-д 5 сум 1 тосгоны 7 багийн 581 тамирчид 2018 оны 08 дугаар сарын 18, 19-ний өдрүүдэд Спорт сургууль, Биеийн тамир спортын ордонд 6 төрөлт спортоор хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдлөө. Тэмцээнд Сүхбаатар сумаас 2 багийн 160 гаруй тамирчид оролцож, багийн нийлбэр дүнгээр 3-р байранд шалгарч, амжилттай оролцлоо.

2018 оны Сум хөгжүүлэх сангийн төсөл хүлээн авч, нийт 38 иргэний төсөл ирсэн. Үүнийг 2018 оны 08 дугаар сарын 22-ны өдөр Сүхбаатар сумын сум хөгжүүлэх сангийн "Төсөл сонгон шалгаруулах орон тооны бус салбар зөвлөл"-ийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэлээ.

Дархан-Уул аймгийн Орхон суманд Монгол ногоо төслөөс зохион байгуулсан "Ургамал хамгааллын бодисын хэрэглээ, ашиглалт" сэдвийн сургалтанд Сүхбаатар сумын 10 ногоочин хамрагдлаа. Мөн Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн төслийн судалгааны баг Сүхбаатар сумын жимс жимсгэнэ тариалагч иргэдийн үйл ажиллагаатай танилцлаа.

Үндэсний хоршоологчдийн нэгдсэн чуулганд Сүхбаатар сумын хоршоологч идэвхитэй оролцсон бөгөөд тус арга хэмжээний үеэр зохион байгуулагдсан үзэсгэлэн худалдаанд хоршоологчид өөрсдийн нэрийн бүтээгдэхүүнээрээ оролцлоо.

Сэлэнгэ аймгийн ХАА-н хоршоологчдын холбооноос зохион байгуулсан "Ургацын далай" сэдэвт тогоочдын ур чадварын уралдаанд аж ахуйн нэгж, албан байгууллагын тогоочдыг оролцууллаа.

Сумын үнийн зөвшлийн комисст өргөдөл гаргасан iPhone 5, Samsung J3 зэрэг 639,000 төгрөгийн гар утас, цахилгааны утасны улмаас гал гарч шатсан айлын 20,182,000 төгрөг нийт 20,821,000 төгрөгийн хөрөнгөнд үнэлгээ хийж, комиссоор батлуулж ажиллалаа.

Сүхбаатар сумын нутаг дэвсгэрт 2018 оны 07 дугаар сарын 17-ны өдөр хүчтэй аадар бороо орж аюултай нөхцөл байдал үүссэнтэй холбогдуулан шуурхай арга хэмжээ авч бэлэн байдалд ажиллахыг нийт ажилчин албан хаагчдад үүрэг болгосны дагуу, нийтийн эзэмшлийн зам талбай болон айл өрх аж ахуйн нэгжүүдийн хашаа зам талбай, асфальтбетон замууд их хэмжээгээр шороо хуралдаж авто машин, иргэд зорчих боломжгүй болсон тул сэргээн засварлах ажлыг шуурхай зохион байгуулсан.

Хэт халалттай холбогдуулан ард иргэд голын эрэг дагуу амарч зугаалах нь ихэссэнтэй холбогдуулан, амарч зугаалж буй иргэдэд "Ой хээрийн түймрийн аюулаас сэрэмжилье", "Түлсэн гал, асаасан шүдэнз, татсан тамхиныхаа гал, цог, нурмыг унтраахыг анхааруулж байна", "Гол мөрний усанд осолдохоос урьдчилан сээрэмжлье", "Нуур, цөөрөм, гол мөрөн бүхий газраар бага насны хүүхдийг хараа хяналтгүй явуулахгүй байхыг анхааруулж санамж, сэрэмжлүүлэг, зөвлөмжийг иргэдэд тараан ажилласан.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийтийн эзэмшлийн орон сууцнуудад хийгдсэн дээврийн ажил, инженерийн шугам сүлжээний ажлуудад хяналт тавьж улсын комисст хүлээн авч байнгын ашиглалтанд оруулж ажиллалаа.

- ✓ Шарын 1,2,3,6,7,8,9,10,11 р байрууд
- ✓ Цэнхэрийн 18,19,20-р байрууд
- ✓ Төмөр замын 4-58-н айл
- ✓ Гурилын шар байр

Түшиг сүм:

Үр тарианы ургац тогтоох комиссыг байгуулж, 5 аж ахуйн нэгж байгууллага, 2 иргэний тариалсан талбайд тооллого хийлээ. Урьдчилсан дүнгээр сумын хэмжээнд дундажаар 15,3 цн ургац хураан авах боломжтой байна.

Аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг эхний 08-р сарын 24-ний байдлаар төлөвлөгөө 141582.7 мянган төгрөг бол гүйцэтгэл 141582.7 мянган төгрөгийн биелэлттэй байна. 08-р сарын 24-ний байдлаар төлөвлөгөө 69720.5 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 50628.6 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж 72.6%-ийн биелэлттэй байна.

Ой хээрийн түймэр, гамшгаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд малчин айл өрхийн өвөлжөө хаваржааны хашаа, саравчинд дутуу унтраасан малын өтөг бууцыг айл өрх бүрээр шалган ажиллалаа. “Хар горхи”-д Улаанбаатар Төмөр Замын харьяа мод боловсруулах үйлдвэр 2018 онд олгосон модны хуваарийн дагуу 1000 м3 хэрэглээ, 200 м3 түлээ бэлтгэх тээвэрлэх үйл ажиллагаанд өдөр бүр хяналт тавьж ажилласан. Төгсгөлийн акт үйлдэж, мод бэлтгэсэн талбайг цэвэрлүүлсэн. Мөн байгалийн дагалт баялаг жимсний хураамжийг бичиж хяналтыг тогтмол тавьж ажиллассан.

Эрүүл мэндийн төвийн амбулатороор нийт 121 иргэн үйлчлүүлснээс урьдчилан сэргийлэх үзлэгээр 52 хүн хамрагдсан. Түргэн тусламжийн төвд нийт 28 дуудлага ирсэнээс алсын 5 дуудлага, ойрын 23 дуудлага ирсэн. Нийт 2004 хүн амаас нөхөн үржихүйн 450, 0-1 насны 32, 0-5 насны 195 хүүхэд, өндөр настан 143, хөгжлийн бэрхшээлтэй 106, диспансерийн хяналтанд 206 иргэн байна.

“Мобиком” ХХК-ний сүлжээний антен байрлуулах ажилд ажил хайгч 10 иргэнийг түр ажлын байраар, “Хүрэл дээж” ХХК-ний өрөмдлөгийн туслах ажилтнаар 2 иргэнийг, тус компанийн тогоочийн түр орон тоонд 1 иргэнийг тус тус ханган ажиллууллаа.

Хушаат сүм:

2018 оны ургац тогтоох, ургацын баланс гаргах ажлын хэсэг 4 хүний бүрэлдэхүүнтэй томилогдон ажиллаж, ургацын урьдчилсан балансыг гаргалаа. 2018 онд 9535 га-д үр тариа тариалснаас 566 га талбай тэжээлд шилжиж 8969 га-с 14707 тн буюу 1-га-с 16,3 цн үр тариа, үүнээс улаанбуудай 8469 га-с 14162 тн / 16,7 цн га / , 119 га-с 148 тн тэжээлийн ургамал /12,4 цн га/, 2336 га-с 1565 тн рапс /6,7 цн га/233,5 га-с 2698 тн /115,5 цн га / төмс, 218,5 га-с 2517,5 тн /115,2 цн га / хүнсний ногооны ургац хураан авах урьдчилсан дүн гарсан. Уринш 9854 га бэлдэж, үүнээс химийн 4984 га, механик 4870 га чанар сайтай уринш бэлдсэн.

Өвөлжилтийн бэлтгэл байдал хангах зорилгоор ойн цэвэрлэгээ явуулж нийт 382 м3 модыг 48 өрхөд олгож ойн нөөц ашигласаны төлбөрт 636120 төгрөгийг орон нутгийн орлогт оруулсан. Үүнд: хэрэглээний мод 48м3, түлшний мод 334м3 модыг тус тус олгосон.

“Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх” ажлын хүрээнд Даагат 1-р багийн нутаг Могойт зуслан, Мөнхтолгой 2-р багийн нутаг Бугат өвөлжөөтүс бүрээс цэг авч, 9 цэгийн зураг, 4 орчны зураг авч Sample point программаар боловсруулан LM-2 програмд оруулан тайланг гаргаж өгсөн. 2018 оны 08 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн хадлангийн газрын өргөдөл авч эхэлсэн. Нийт 58 иргэн 1 аж нэгжтэй хадлангийн газар ашиглах байгуулаад байна.

Нийгмийн даатгал болон Эрүүл мэндийн даатгалын тухай хуулиудыг 2018 оны 08-р сарын 29 хүртэл 498 хүнд сурталчилж, иргэдийг сайн дурын даатгалд хамрагдах талаар танилцуулга, тараах материал, гарын авлагыг 198 хүнд тараасан. 2018 оны 08-р сарын 29 хүртэл Нийгмийн даатгалын шимтгэлд 5 байгууллага, 29 аж ахуйн нэгжийн 188605.9 мянган төгрөгийн, нийгмийн даатгалын сайн дурын даатгуулагч 121

иргэний 25526.3 мянган төгрөгийн шимтгэл, эрүүл мэндийн заавал даатгалд 144 иргэний 6985.4 мянган төгрөгний тус тус хураамжийг дансанд орууллаа.

Улсын бүртгэлийн тухай хууль, Иргэний бүртгэлийн тухай хууль, бусад холбогдох хууль журмын дагуу төрөлт-5, эцэг тогтоолт- 1, гэрлэлт -1, шилжин явсаны-6 үүнээс, аймаг хооронд 1, сум хооронд 1, шилжин ирсний -6, нас барсаны -3, цахим үнэмлэх дахин авах-4, биеийн давхцахгүй өгөгдлийн -13, үл хөдлөх хөрөнгийн эрхийн-3, газар өмчлөх эрхийн-2, иргэний үнэмлэх олголтын -16 нийт 60 бүртгэл хийж 6 гэрчилгээ бичиж олгосон. Орон нутгийн дансанд 55500, УБСГ-н дансанд 238500 төгрөгийн орлого оруулсан байна.

Хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажлын хүрээнд сургуулийн урсгал засварын ажлыг хийж, дотуур байрны коридори, сургуулийн дээд, доод давхарын шал, шат, гал тогооны өрөө болон сурагчдын хоолны заалыг будсан.

Даагат багийн малчдын өдөрлөгийг Өвөр хуурайд зохион байгуулж, нүүдлийн номын сан, угийн бичгийг хөтлөх тухай сургалт, гар бөмбөг, АХА, үдшийн цэнгүүн, Караоке тэмцээнүүдийг тус явууллаа.

НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН :

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Ш.ЭНХМАА

ХЯНАСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Ө.СУВДАА